


МОНГОЛ УЛСЫН ИХ СУРГУУЛЬ
НОМЫН САН

ШИНЭ НОМЫН МЭДЭЭ
2021 №04/2
(2021.12 САР)



Эмхэтгэсэн: Номзүйч М.Золбоо

М.Пүрэвсүрэн

Улаанбаатар хот
2022 он

ГАРЧИГ

ФИЗИК-МАТЕМАТИКИЙН ШИНЖЛЭХ УХААН.....	1
ХИМИЙН ШИНЖЛЭХ УХААН.....	1-2
ГЕОЛОГИ. ГАЗАРЗҮЙН ШИНЖЛЭХ УХААН.....	2-3
БИОЛОГИЙН ШИНЖЛЭХ УХААН.....	3-4
ТЕХНИКИЙН ШИНЖЛЭХ УХААН.....	4-6
НИЙГМИЙН ШИНЖЛЭХ УХААН.....	7
ТҮҮХИЙН ШИНЖЛЭХ УХААН.....	7-14
ЭДИЙН ЗАСГИЙН ШИНЖЛЭХ УХААН.....	14-17
УЛС ТӨРИЙН ШИНЖЛЭХ УХААН.....	18-24
ТӨР ЭРХ, ХУУЛЬ ЦААЗЫН ШИНЖЛЭХ УХААН.....	24-27
ЦЭРГИЙН ШИНЖЛЭХ УХААН.....	28-29
ШИНЖЛЭХ УХААН СУДЛАЛ.....	29-31
БОЛОВСРОЛ. СУРГАН ХҮМҮҮЖҮҮЛЭХ УХААН.....	31-32
МУЗЕЙН АЖИЛ.....	33
ХЭЛ БИЧГИЙН ШИНЖЛЭХ УХААН.....	34
УРАН ЗОХИОЛ.....	35-37
ШАШИН СУДЛАЛ.....	38-39
ГҮН УХААН.....	39-41
СЭТГЭЛ СУДЛАЛ.....	41
НОМ ЗҮЙН ЛАВЛАГААНЫ ГАРЫН АВЛАГА.....	42-44
ГАДААД ХЭЛ ДЭЭРХ НОМ, ЗОХИОЛ.....	45-57

Товчилсон үгийн тайлбар:

БУУТ- Байгалийн ухааны уншлагын танхим /306 тоот/

НХУУТ- Нийгэм, хүмүүнлэгийн ухааны уншлагын танхим- I,II /211, 108 тоот/

ГНОФ- Гэрээр ном олгох фонд-I,II,III /110,201,401 тоот/

ГФ- Гадаад номын фонд /411 тоот/

ЛавФ- Лавлагааны фонд /409 тоот/

ЭШФ- Эрдэм шинжилгээний фонд /411 тоот/

БС- Бизнесийн сургуулийн номын сан /Хич-V 505 тоот/

ХЗС- Хууль зүйн сургуулийн номын сан /Хич-III 205 тоот/

ОУХНУС- Олон улсын харилцаа, Нийтийн удирдлагын

сургуулийн номын сан /Хич-V 304 тоот/

ФИЗИК-МАТЕМАТИКИЙН ШИНЖЛЭХ УХААН

Нямсүрэн О. **Интеграл ба дифференциал тоолол** / Эх бэлт. Ц.Баатархүү; Хавтасны диз. Б.Эрдэнэбулган.- УБ.: Соёмбо принтинг, 2019.- 79х.- ISBN 978-9919-22-145-4.

Энэхүү ном нь орчин үеийн дээд боловсролын хөтөлбөрийн шинэчлэл ба сургалтын технологийн дэвшлийн зорилтод нийцүүлэн туурвисан иж бүрэн онолын гарын авлага юм. Олон хувьсагчийн функцийн дифференциал тоолол, давхар интеграл, муруй шугаман болон гадаргуугийн интегралуудыг багтаасан агуулгатай.

22.161.1я7

Н 988

/БУУТ-2/

ЭШФ Т 25209-25210



Бинмор К. **Тоглоомын онол**: Тун товчхон танилцуулга / Орч. Ц.Даваадорж; Хян. Ч.Өнөрбаяр, Л.Отгонбаяр; Техник ред. Х.Наранцацрал; Хавтасны диз. Н.Бямбацогт; Эх бэлт. Ж.Мөнхсайхан.- УБ.: Мөнхийн үсэг, 2021.- 196х.- ISBN 978-99973-938-8-3.

Энэхүү бүтээл нь Тоглоомын нэр; Аз; Цаг хугацаа; Тогтсон ёс журам; Харилцан ажиллах; Мэдээл; Дуудлага худалдаа; Хувьслын биологи; Хэлэлцээр ба эвсэл; Татвар ба парадокс гэсэн сэдвүүдийн хүрээнд бичигджээ.

22.18

Б 487

/БУУТ-4, ГНОФ-4/

ЭШФ Б 30703-30704



Нямсүрэн О. **Механик**: Дэвт. II: Физик хөтөлбөр: Инженер байгалийн ухааны ангид зориулав / Эх бэлт. Д.Ганчимэг.- УБ.: Адмон принт, 2021.- 103х.- ISBN 978-9919-25-638-8.

Энэ номыг физик, инженерийн чиглэлээр суралцах хүсэлтэй ба сурч байгаа сурагч нарт зориулав. Уг бүтээлд инженерийн суурь мэдлэгт физикийн онол чухал үүрэгтэй талаар мөн амьдрал дээр тэдний хөтөлбөрүүдийн хооронд залгамж холбоо, онол практикийн уялдаа нь харьцангуй сул тусгагдсан байгааг харгалзан физикийн хөтөлбөрт сэдэв болон заах аргын зохих өөрчлөлтүүдийг хийсэн ажлын дүнг багтаажээ.

22.2

Н 984

/ГНОФ-10, БУУТ-5/

ЭШФ Т 25199-25201



ХИМИЙН ШИНЖЛЭХ УХААН

Болормаа О. **Химийн урвалжууд, анализад бэлтгэх аргууд** / Хян. Ч.Буян; Эх бэлт. М.Долгормаа; Диз. М.Билгүүн.- УБ.: МУИС хэвлэх үйлдвэр, 2021.- 256х.- ISBN 978-9919-20-494-5.

Уг номонд химийн болон бусад лабораторид ашиглагддаг бодис урвалжийг бэлтгэх, арга аргачлал, бодис урвалжийн аюулгүй ажиллагаа зэргийн талаар бичжээ. Энэхүү номыг бүх төрлийн химийн лабораторийн мэргэжилтнүүд, хими, биологи, физик, газар зүй, хүрээлэн буй орчны чиглэлээр суралцаж буй оюутнууд, болон ерөнхий боловсролын сургуулийн багш нарт зориулав.



24.2

Б 559

/БУУТ-10, ГНОФ-10/

ЭШФ Т 24994-24996



Монхообор Д., Цэвэгсүрэн Н. **Органик хими I: Их, дээд сургуулийн оюутан, магистрант, докторант нарт зориулсан сурах бичиг** / Хян. Д.Монхообор; Диз. Б.Үүрийнтуяа.- 2 дахь хэвл.- УБ.: Нандир, 2021.- 446х.- ISBN 978-9919-25-822-1.

Энэхүү бүтээлд органик химийн тодорхойлолт, судлагдахуун, ач холбогдол, органик нэгдлийг нэрлэх ангилах зарчим, органик бодис, органик молекулын онцлог, ковалент холбоо үүсэх зарчим, молекул орбиталийн онолын үндэс, органик молекулын бүтэц, шинж чанарыг судлах аргууд, органик урвалын төрөл, механизм, нүүрстөрөгч, устөрөгчийн атомуудаас тогтох алкан, алкен, алкадиен, алкин, ареныудын онцлог шинж, байгальд орших хэлбэр, молекул бүтцийн онцлогууд, бусад органик нэгдлүүдийг гаргах эх түүхий эд болох тухай ойлголт, төрөл бүрийн нүүрсустөрөгчдийн молекул дахь нэг буюу хэд хэдэн устөрөгч атомыг янз бүрийн функциональ бүлгээр халснаар маш олон тооны янз бүрийн шинж чанартай органик нэгдлүүдийн бүхэл бүтэн анги бүлгүүдийг гарган авах боломжтой талаар мөн органик химичдийн заавал судалсан байх шаардлагатай зарим элементорганик ба полимер нэгдлүүд, гетероцагирагт ба биоорганик нэгдлүүдийн энгийн төлөөллүүдийг багтаажээ.

24.2я73

М 706

/БУУТ-7, ГНОФ-10/

ЭШФ Т 24997-24999



Болормаа О., Буян Ч. **Аналитик химийн онолын тайлбартай сорилго** / Эх бэлт. Г.Алтанцэцэг, Н.Ариунзул.- УБ.: МУИС хэвлэх үйлдвэр, 2021.- 198х.- ISBN 978-9919-25-653-1.

Энэхүү бүтээлд чанарын анализын онолын асуудал, аналитик химийн онолын үндэс, тооны анализын аргууд, багажит анализын аргуудыг багтааж, 500 гаруй сорилгуудыг нэг ба олон сонголтын хувилбартайгаар боловсруулж, сорилго бүрийн дараа хариултыг онолын тайлбартайгаар оруулжээ.

24.4

Б 559

/БУУТ-6, ГНОФ-10/

ЭШФ Т 24991-24993

ГЕОЛОГИ. ГАЗАРЗҮЙН ШИНЖЛЭХ УХААН



Мижиддорж Р. ба бус. **Хур тунадасны хэлбэлзэл, дулаарал, хуурайшил** / Д.Дуламсүрэн, Д.Оюунбаатар; Ред. П.Гомболүүдэв; Эх бэлт. Г.Лхамжав; Хавтасны диз. У.Мөнх-Эрдэнэ.- УБ.: Соёмбо принтинг, 2021.- 179х.- ISBN 978-9919-25-492-6.

Энэхүү бүтээлд ХХI зуунд дэлхийн дулаарлын нөлөөгөөр Монгол орны цаг уур хэт дулаарч байгалийн бүсүүдэд ихээхэн өөрчлөлт орох, одоогийн хээрийн бүс нь ерөнхийдөө говийн шинжтэй болж, хуурайших, гадаргын усны нөөц улам багасах, бэлчээр доройтох, тариалангийн ургац алдах зэргээр экосистем, байгаль, нийгэмд илүү

ноцтой сөрөг үр дагаврыг авчирч болзошгүй талаар тусгажээ.

26.23

М 521

/БУУТ-7, ГНОФ-10/

ЭШФ Т 25127-25129

Уур амьсгалын өөрчлөлт, түүнд дасан зохицох: Сургагч багш нарт зориулсан гарын авлага.- УБ., 2021.- 350х.

“Уур амьсгалын өөрчлөлт, түүнд дасан зохицох” гарын авлагад дэлхийн уур амьсгалын системийн уялдаа холбоо, хэлбэлзэл, гадаад хүчин зүйл, уур амьсгалын өөрчлөлтийг бий болгож буй үндсэн шалтгаан, хүний үйл ажиллагааны нөлөөлөл, цаашилбал нэгэнт бий болсон энэхүү өөрчлөлтийг сааруулах, өөрчлөлтөд дасан зохицох бодлого, арга хэмжээний талаар тусгажээ.

26.237я7

У 594

/БУУТ-14, ГНОФ-29/

ЭШФ Т 25095-25099




Эрдэмтэд, судлаачдын тухай өгүүлэх нь / Ред. Д.Даш; Техник ред. Х.Цогбадрал; Эх бэлт. Д.Ганчимэг.- УБ.: Адмон, 2021.- 312х.- ISBN 978-9919-25-603-6.

Энэхүү бүтээлд, байгалийн олон янз байдал, тэдгээрийг бүрэлдэхэд нөлөөлсөн байгалийн гадаад болон дотоод хүчин зүйлсийг бүс нутаг, тив, дэлхийн хэмжээнд харьцуулан авч үзсэн эрдэмтдийн бүтээлийн товч болон эрдэмтдийн намтар түүхийг түүвэрлэн авч оруулжээ.

26.8(1)г

Э 739

ЭШФ Т 25130-25132



БИОЛОГИЙН ШИНЖЛЭХ УХААН

Санчир Ч. **Ургамлын нэвтэрхий толь** / Мэргэжлийн ред. Ш.Дариймаа; Хариуцлагатай ред. Д.Цэцэгмаа; Төслийг удирд. Б.Одончимэг; Хэвлэлийн газрын ред. М.Билгүүнчимэг, Э.Пүрэвжаргал, Э.Уранбилэг; Тех. ред. Д.Очирмаа; Эх бэлт. Д.Пүрэвсүрэн.- УБ.: Адмон принт, 2021.- 604х.- ISBN 978-99973-1-933-3.

Энэхүү толь бичигт Монгол орон болон дэлхий даяар түгээмэл ургадаг 700 гаруй ургамлыг цагаан толгойн дэсээр байрлуулж, ургамлын ерөнхий шинж, тархац нутаг, ургах газар, гол төлөөлөл, хэрэглээ, ач холбогдол, ондоо нэр зэргийн талаар тусгажээ. Мөн толь хэрэглэгч хүн нэг овогт хамааралтай ургамлын төрөл, зүйлийг хайхад дөхөм болгох үүднээс индекс хийж, хуудасны дугаарыг заан хавсралт хэсэгт монгол, латин нэрийг жагсааж өгчээ. Уг нэвтэрхий толь нь зөвхөн мэргэжлийн хүрээнийхэнд бус ургамал сонирхон судалдаг, танин мэдэхийг зорьсон хүн бүрд хэрэгцээтэй тул танин мэдэхүй, хэрэглээний болоод эрдэм шинжилгээний ач холбогдолтой.

28.5я2

С 328

/БУУТ-4, ГНОФ-4/

ЭШФ Б 30636-30637



Амброз Ж. **Амьтан:** Амьтдын нууцлаг ертөнцөөр / Ред. Н.Нандинчимэг, Б.Нэргүй, Д.Хүрэлхүү; Орч. Б.Эрдэнэбаяр; Зөвл. Б.Болдбаатар; Диз. Н.Бямбацогт.- УБ.: Нэпко, 2021.- 333х.- ISBN: 978-9919-500-69-6

Хурц тод гэрэл зураг, энгийн ойлгомжтой тайлбараараа энэ ном зүйл бүрийн амьтдын биеийн бүтэц, зан ааш, гоо үзэмж бүхнийг дэлгэн харуулж үс, хайрс, сахал, сүүл, гээд эд эрхтэн бүгдийн үүрэг, шинж чанарыг тайлбарлан таниулжээ.



28.6
А 521

/БУУТ-4, ГНОФ-4/

ЭШФ Т 24936-24937



Брайсон Б. **Бие эрхтэн** **Эзэгнэн төрөгсөд** / Техник ред. В.Уянга, Н.Нандинчимэг; Диз. Н.Бямбацогт; Хавтасны диз. Н.Бямбацогт; Эх бэлт. Д.Цэрэндулам.- УБ.: Нэпко, 2021.- 470х.- ISBN 978-9919-500-76-4.

Энэхүү бүтээлд хүний бие эрхтэн яаж ажилладаг, эрхтнүүд хоорондоо хэрхэн холбогдож мөн мөхдөг талаар, хүний биеийн бүтэц, тархи, толгой, арьс үс, зүрх судас, дархлааны тогтолцоо, уушиг, нойр, хооллолт, хөдөлгөөн, өвчин, хорт хавдар, эмийн сайн муу тал гээд хүний биетэй холбоотой ер бусын олон баримтууд багтжээ.

28.7
Б 681

/БУУТ-3, ГНОФ-4/

ЭШФ Т 24927-24928



Свансон Э. **Иогийн шинжлэх ухаан** **Анатоми физиологио ойлгон дасгалаа төгөлдөржүүл** / Ред. Н.Нандинчимэг, Т.Ялгуун, Г.Норжмоо; Орч. Т.Ариунсанаа; Өмнөх үг Ж.Нямсүрэн, Ж.Даваажаргал; Диз. Д.Цэрэндулам, Н.Бямбацогт.- УБ.: Нэпко, 2021.- 216х.- ISBN: 978-9919-500-96-2.

Иогийн шинжлэх ухаан номд хүн иогийн байрлалд орж, хөдөлж, зогсох үед цусны урсгал, амьсгалын шинж чанар хэрхэн өөрчлөгддөг болон иог хийх арга зүйг бодит баримт, тайлбар зургуудаар нэг бүрчлэн тайлбарласан байна. Дасгалаа төгөлдөржүүлж, иогийн ач тусыг оюун санаа, бие махбоддоо мэдрэн хүртэхэд тань энэ ном хамгийн шилдэг гарын авлага болно.

28.706+75.6

С 403

/БУУТ-4, ГНОФ-4/

ЭШФ Т 24929-24930

ТЕХНИКИЙН ШИНЖЛЭХ УХААН



Бодин М.А. **Хиймэл ухаан: Тун товчхон танилцуулга= Artificial intelligence: A very short introduction** / Ред. С.Баяраа; Орч. Т.Ариунсанаа; Техник ред. Б.Болдбаатар, В.Уянга; Хавтасны диз. Н.Бямбацогт; Эх бэлт. Д.Цэрэндулам.- УБ.: Мөнхийн үсэг, 2021.- 191х.- ISBN 978-9919-500-91-7.

Энэхүү бүтээлд хүний тархи яаж ажилладаг вэ, тархи яг юу хийдэг вэ, хэрхэн тооцоолол хийдэг вэ, ямар мэдээлэл үүнд хэрэг болдог вэ гэх мэт асуултын хариу мөн компьютероор хүссэн зүйлсээ хийлгэх, хиймэл ухааныг ашиглан хүн болон бусад амьд зүйлсийг шинжлэн судалж, загвар бүтээх гэсэн шинжлэх ухаанч зорилгын талаар тусгажээ.

32.816
Б 532

/НХУУТ-4, ГНОФ-4/

ЭШФ Б 30707-30708

Гүндсамбуу Б. **Python, Django, Javascript ашиглан веб хөгжүүлэх нь** / Ред. Б.Мөнхнасан; Хавтасны диз. Б.Лхамжав.- УБ., 2021.- 314х.- ISBN 978-9919-24-855-0.



Энэхүү ном нь орчин үеийн веб программчлалын тулгуур ойлголтууд, ашиглах хэрэгсэл, хөгжүүлэх программчлалын хэлний тухай агуулгыг багтаасан. Номыг уншиж, дагалдах жишээ программуудыг туршсанаар Python, JavaScript, SQL хэл, Django, React, Bootstrap зэрэг фреймворкуудыг ашиглан веб программ хөгжүүлэх, API бичиж турших, хэрэглэгчийн интерактив интерфэйс үүсгэх, GitHub зэрэг үүлэн технологийн үйлчилгээг ашиглаж сурах болно. Веб хөгжүүлэх сонирхолтой эхлэн суралцагч, программчлалын хэлний тодорхой мэдлэгтэй хүмүүс ашиглах боломжтой.

32.973-018.2

Г 856

/БУУТ-10, ГНОФ-15/

ЭШФ Т 25121-25123

Мөнхнасан Ч. **Программ хангамжийн инженерчлэлийн үндэс** / Хян. А.Алтангэрэл; Эх бэлт. Ч.Мөнхнасан, М.Билгүүн; Диз. Ч.Мөнхнасан.- УБ.: МУИС-ийн хэвлэх үйлдвэр, 2021.- 405х.- ISBN 978-9919-25-787-3.



ПХ-ийн инженерчлэлийн үндсэн суурь ойлголтуудыг багтаасан энэхүү ном нь дөрвөн хэсэг арван таван бүлэг, индексжүүлэлтийн хэсгээс бүрдсэн. Уг номд ПХ-ийн процесс, системийг хөгжүүлэх процессын загварууд, тэдгээрийн онцлог, хэрэглээ, давуу болон сул талууд, системийг хөгжүүлэх орчин үеийн аргачлал болох шалмаг хөгжүүлэлтийн аргачлалын тухай, шаардлагын тодорхойлолтоос эхлээд системийн нэвтрүүлэлт, засвар өөрчлөлт болон хувьсал хөгжлийн үе шатууд хүртэлх ПХ-ийн хөгжүүлэлтийн үндсэн үе шатууд болох системийн шаардлага, шинжилгээ, зохиомж, тест, хүргэлт засвар өөрчлөлтийн тухай буюу инженерчлэлийн үндсэн үйл ажиллагаанууд, эдгээр үйл ажиллагаануудыг хийхэд зайлшгүй шаардлагатай үйлдлүүд, тэдгээрийг хийхэд ашиглагддаг арга техник, хэрэгсэл, ПХ-ийн чанарын удирдлага, чанарын баталгаа ба чанарын хяналт, чанарын хэмжилтийн талаар танилцуулна.

32.973-018.2

М 816

/БУУТ-7, ГНОФ-15/

ЭШФ Т 25124-25126

Холмс Д.Е. **Их өгөгдөл**: Тун товчхон танилцуулга / Ред. У.Дөлгүүн, М.Эрхэмбаяр; Техник ред. В.Уянга; Орч. Т.Ариунсанаа; Хавтасны диз. Н.Бямбацогт; Эх бэлт. Д.Цэрэндулам.- 2 дахь хэвл.- УБ.: Мөнхийн үсэг, 2021.- 132х.- ISBN 978-99978-51-48-2.




Энэхүү бүтээлд Их өгөгдөл гэж юу болох; Их өгөгдлийн тэсрэлт; Их өгөгдлийг хадгалах нь; Их өгөгдлийн шинжилгээ; Их өгөгдөл ба анагаах ухаан; Их өгөгдөл, их бизнес; Их өгөгдөл аюулгүй байдал ба Снөүдэний явдал; Их өгөгдөл ба нийгэм гэсэн сэдвүүдийн хүрээнд энэ зүйл дэлхий ертөнцийг хэрхэн өөрчилж байгаа, бидний өдөр тутмын амьдралд болон бизнест ямар нөлөөтэй талаар тусгажээ.

32.973

Х 424

/БУУТ-4, ГНОФ-4/

ЭШФ Б 30705-30706



Хоол хүнс: Иж бүрэн зурагт хөтөч.- УБ.: Нэпко, 2021.- 255х.- ISBN 978-0-2412-8939-6.

Энэ ном танд хүн юу иддэг, тэр нь ямар учиртайгаас эхлээд амт гэж юу болох, яагаад сайхан амтагдан таны дуршлыг татдагийн учрыг тайлбарлана. Сүүлийн үед биднийг айлгах хэрэгсэл болсон “Генийн өөрчлөлттэй хүнс” ямар учиртайг тайлбарлан, ямар хоол сайн болох, яаж хооллох зөв гэдгийг номлож зүдрээхгүй, аль нэгэн зөв сайн хоолыг ид гэж албадахгүй. Зүгээр л хоол хүнсний учир шалтгаан, хэрэгцээ нөлөөг энгийн үгээр тайлбарлажээ.


36.992+51.230

X 462

/БУУТ-4, ГНОФ-4/

ЭШФ Т 24934-24935

АНАГААХЫН ШИНЖЛЭХ УХААН



Хулан Б. **Таргалалтын анатоми** / Хян. Я.Алтанзаяа, Л.Мөнх-Эрдэнэ, Д.Гангаа, Т.Дулмаа; Эх бэлт. Д.Баттулга; Хавтасны зур. Э.Бэндэрьяа.- УБ.: Мөнхийн үсэг, 2018.- 223х.- ISBN 978-99978-1-176-9.


Уг бүтээлд илүүдэл жингээ хасах энгийн арга зам, эрүүл байхын тулд жинхэнэ эрүүл хүнс болох уламжлалт Монгол хоол хүнсээ идэж хэрэглэх, хоолны дэглэм, монгол хүнд тохирох зоог, идээгээ зөв, өргөн дэлгэр хэрэглэвэл эм эмчилгээ болох талаар тусгажээ.

51.1

X 681

/БУУТ-3/

ЭШФ Б 30746-30747



Цолмон Ж., Маралгуа О. **Гавал, нүүрний анатоми, радиографийн атлас:** Толгойн хажуугийн телерентген зургийн оношилгоо / Ред. Д.Амгаланбаатар; Эх бэлт. Ж.Цолмон; Диз. Б.Наранбаяр; Зөвлөх Kim Neun; Хавтасны загвар Г.Ганхуяг.- УБ.: Тод бичиг, 2021.- 234х.- ISBN 978-9919-25-123-9.

Энэхүү бүтээлд толгойны хэмжилтзүйн антропологийн 150 гаруй цэгүүдийг тодорхойлон бичиж түүнийг яаж тодорхойлж, бичиглэл хийхийг тод тусгасан байна. Толгойны антропологийн хэмжилтзүйн цэгүүд бол нэг дор олон цэгүүд байрлаж түүнийг зураг дээр тэмдэглэхэд нэн бэрхшээлтэй байдаг. Энэ бэрхшээлийг арилгах үүднээс зохиогч толгойн хажуугийн телерентгенграфи дээр хамгийн гол цэгийг тэмдэглэж түүнийг тодорхойлох аргыг тод бичээд аажмаар бусад цэгүүдийг байрлал ач холбогдлын хүрээгээр нь цэгнэж олон хувилбар зургууд дээр тодорхойлсон нь судлаачид болон мэргэжлийн эмч хүнд онцгой чухал мэдээлэл олгож чадах бүтээл болсны дээр толгойн хажуугийн телерентгенграфи дээр чамархай, нүдний аяга, ухархай, хамрын хөндий зэрэг олон чухал анатомийн бүтцүүдийг тус тусад нь авч үзээд онцгой ач холбогдол бүхий цэгүүд, мөн гадна түрк эмээл, дух, хоншоор, суурь ясны дотор байдаг хамрын дайвар хөндийнүүдийг тус тусад нь ялган зураглал хийжээ.

53.6я73

Ц 767

/БУУТ-7/

ЭШФ Т 24985-24987

НИЙГМИЙН ШИНЖЛЭХ УХААН

Хэнд Д.Ж. **Статистик: Тун товчхон танилцуулга= Statistics: A very short introduction** / Орч. Т.Ариунсанаа; Техник ред. В.Уянга, Н.Нандинчимэг; Хавтасны диз. Н.Бямбацогт; Эх бэлт. Д.Цэрэндулам.- УБ.: Мөнхийн үсэг, 2021.- 130х.- ISBN 978-9919-500-87-0.

Энэхүү бүтээлд эл салбарын талаарх ерөнхий ойлголтыг тойм байдлаар өгч, статистикийн ерөнхий философи, үзэл санаа, хэрэглүүр болон хэрэглэдэг аргачлалууд, орчин үеийн уг салбар хэрхэн ажилладаг болон статистик яагаад чухал эсэх талаар тусгажээ.



60.6

X 911

/НХУУТ-4, ГНОФ-4/

ЭШФ Б 30709-30710

ТҮҮХИЙН ШИНЖЛЭХ УХААН

Минжүүр Т. **Монгол туг** / Хэвлэлд бэлт. Ц.Түмэн.- УБ.: Мөнгөн пресс, 2020.- 203х.- ISBN 978-9919-20-777-9.

Уг номд тусгагдсан монголын түүхийн соёлын утга бүхий өгүүллүүд нь монголчуудын цагаан, хар болон алаг гурван ялгуусан тугийн соёл түүхэнд зөв оновчтой магадлалт, нотлолт хийхийг зорьжээ. Тэрчлэн цагаан, хар болон алаг гурван ялгуусан тугийн соёлыг бэлгэдлийн соёл, шашин суртахууны соёл, уламжлалт үйлдэх соёл гэсэн гурван төрөлд ангилж, тус бүрийн агуулгад тайлбар хийсэн байна.



63.2(1)

M 557

/НХУУТ-3/

ЭШФ Т 25251-25253

Хүрээний сайдын газарт холбогдох хоёр зүйл сурвалж бичиг: Том. XIII: Fasc. 1-2 / Ред. Ц.Цэрэндорж; Эх бэлт. Г.Лхамжав; Хавтасны диз. Ц.Түмэнжаргал; Манж хэлнээс орч. Б.Нацагдорж; Хятад хэлнээс орч. О.Оюунжаргал; Тайлбар зүүлт хийсэн Б.Нацагдорж, О.Оюунжаргал.- УБ.: Соёмбо принтинг, 2021.- 341х.

Тус сурвалж нь дорно дахины уламжлалт дэвтэр хэлбэртэй товхисон 24.9x13.1см хэмжээтэй, тогтуун хичээнгүй тигээр бэхээр бичсэн 115 хуудас бүхий бөгөөд нүүр хавтсанд номын сангийн бүртгэлийн дугаарыг наасан бөгөөд дотор талд сурвалжийн нэрийг Хүрээний хэргийн зүй хэмээн ханз үсгээр зүүн дээд буланд улаан өнгийн цаасан дээр тусгайлан бичиж наажээ. Манж хэлний бичвэрийг нэг нүүрт 8 мөрөөр бичсэн бол хятад хэлний бичвэр нь нэг нүүрт есөн мөр байна. Уг хоёр эхийг тус тусад нь зохион бичээд нийлүүлэн нэгэн дэвтэр болгож үджээ. Энэхүү сурвалжийн агуулга нь Зарлигаар зарсан тамга бүхий Хүрээний хэрэг шийтгэгч сайдын түшмэлийн тогтолцоо бөгөөд цалин хөлс, түшмэл, морь унаа зэргийн талаар дэлгэрэнгүй дурджээ.



63.2(1)

X 845

/НХУУТ-2/

ЭШФ Т 25174-25176



Брүүк Т. **Их улс:** Хятад ба дэлхий / Техник ред. Н.Нандинчимэг; Эх бэлт. Д.Цэрэндулам; Орч. Т.Ариунсанаа; Хавтасны диз. Н.Бямбацогт.- УБ., 2021.- 383х.- ISBN 978-9919-500-86-3.

Хятад улс байгуулагдсан цаг үе нь МЭӨ III зуун бус, харин Монгол ертөнцөд залгиулсан XIII зуунаас эхтэй гэжээ. Тодруулбал, Чингис хаанаас эхтэй Монголын байлдан дагуулал Хятад оронд асар гүн нөлөө үзүүлж, уг орныг хуучны хэлбэр загвараас нь салган Эзэнт гүрэн болгон хувиргасан түүхэн үнэнийг дэлхий нийтэд зохиогч энэхүү бүтээлээрээ харуулахыг зорьжээ.

63.3
Б 685

/НХУУТ-3, ГНОФ-4/

ЭШФ Т 25144-25146



Дөлгөөн Б. ба бус. **Ардын хувьсгал:** Үзэл санааны түүх / Б.Батбаатар, М.Бямбасайхан; Хэвлэлийн газрын ред. Б.Батбаатар; Хариуцлагатай ред.- УБ.: Адмон принт, 2021.- 272х.- ISBN 978-99973-1-934-0.

Энэхүү бүтээлд Ардчилал, Бүгд Найрамдах улс мэндэлсэн нь; Модерн хувьсгалын эрин үе; Америкийн хувьсгал; Францын хувьсгал; Октябрийн хувьсгал; Ардын хувьсгалын үйл хэрэгт нөлөөлсөн үзэл санааг зураг ба бичвэрээр хүүрнэхийг зорьжээ.

63.3
Д 585

/НХУУТ-5/

ЭШФ Т 25156-25158



Трифонов Е. **Зөвлөлт, Монгол далд түүх:** Техник ред. Б.Гэрлээ, Б.Нэргүй; Орч. Б.Гэрлээ; Хавтасны диз. Н.Бямбацогт; Эх бэлт. Д.Цэрэндулам.- УБ.: Нэпко, 2020.- 519х.- ISBN 978-9919-500-57-3.

Евгений Трифонов Оросын түүхэнд ЗХУ ямар байр суурьтай вэ? Зөвлөлт засгийн төр барьсан 74 жил Оросын цэрэг, улс төр, эдийн засгийн хөгжлийн алтан үе байсан уу, аль эсвэл уналт доройтол, уруудал мөхлийн эхлэлийг тавьсан уу? Энэ асуултад хүн бүр өөрийнхөөрөө хариулдаг. Ойрын хэдэн үедээ нэгдсэн нэг үзэлд хүрэхгүй л болов уу. Нийгмийн цөм болж буй өнгөрсөн улирснаа

тодотгож, нэгдмэл нэгэн санаагүй байх аваас эргээд манай үндэстэнд аюул занал нүүрлэж, улс үндэстэн ухарч доройтох нигууртай талаар уг бүтээлд дурджээ.

63.3
Т 615

/НХУУТ-5, ГНОФ-5/

ЭШФ Б 30696-30698



Гомбожав Д. **Хатан эжий Хэрлэн, Онон, Туул миний нутаг** / Хян. Ш.Бямбаа, Г.Амгаланбат, Г.Эрдэнэчимэг; Эх бэлт. Г.Эрдэнэчимэг, Г.Амгаланбат; Гэрэл зур. Г.Амгаланбат, Г.Энхмөнх; Диз. С.Нарантуяа.- 4 дэх хэвл.- УБ.: Мөнхийн үсэг, 2020.- 119х.

Энэхүү бүтээлийг Хан Хэнтий-Бурхан Халдун хайрхан уулаас эх ундаргатай, эзэн Богд Чингисийн онгон дархан унаган нутаг, Хатан эжий Хэрлэн, Онон, Туул гурван мөрнөөрөө нэрийдэн Монголын түүх, нийгэм, аж ахуйн түүхэн замналын талаар уг бүтээлдээ дурджээ.

63.3(1)
Г 531

ЭШФ Б 30755-30757

Дэлхийн бахархал Монгол орон= The world pride Mongolia.- УБ.: Дархан принт, 2021.- 532х.- (Байгаль Орчин, Аялал Жуулчлалын Яам).- ISBN 991921503-1.

Энэхүү бүтээлд Монгол орны 21 аймгийг 4 бүст ангилан аймаг тус бүрийн түүх, бахархал болсон үзэсгэлэнт газруудын тайлбаруудыг зургийн хамт оруулж өгсөн ба англи, уйгуржин монгол бичгээр давхар тайлбарлажээ.

63.3(1)

Д 893



ЭШФ Т 25243

Одхүү С. Монголчууд: Өгөгдөл, амин чанар, бусдын нүдээр: Дэвт. I: Герменевтик шинжилгээ / Ред. Б.Даш-Ёндон, Г.Чулуунбаатар; Эх бэлт. Б.Үүрийнтуяа; Хавтасны диз. Э.Доржханд.- УБ.: Соёмбо принтинг, 2020.- 176х.- ISBN 978-9919-23-880-3.

Зохиолч энэхүү бүтээлээрээ монголчууд гэж хэн бэ, хэн байгаад хэн болоод байна вэ, бидний унаган өгөгдөл, амин чанар, өвөр төрх, язгуур шинж, тогтсон дүр юу юм бол, бидний бусдаас ялгарах давуу тал, сайн шинжүүд, өөр ард түмэнтэй харьцуулахад учир дутагдалтай сул тал, гэж орхимоор гэм согог юу байна, бидний мах, цус, ген, харилцаа хандлага, зан араншинд өвлөгддөг дотоод боломж, далд чадамж юунд оршино вэ? гэсэн асуултуудад хариулт өгөхийг зорьжээ.

63.3(1)

О 201

/НХУУТ-5/

ЭШФ Б 30797-30799



Почекаев Р.Ю. Төр булаагчид ба хуурамч хаад: Монгол угсааны улс гүрнүүдийн түүхэн дэх төрийн эргэлт, үймээн самуун, хуйвалдаан, бослого, тэмцэл / Ред. Д.Хүрэлхүү, Ж.Баттөр; Хян. Д.Хүрэлхүү; Орч. А.Алимаа; Хавтасны диз. Н.Бямбацогт; Эх бэлт. Д.Цэрэндулам.- УБ.: Нэпко, 2020.- 365х.- ISBN 978-9919-500-63-4.

Энэхүү бүтээлд XIII зууны Чингисийн эзэнт гүрний түүхээс эхлэн XX зуунд Дундад Азид бие даасан хаант төр байгуулах оролдлогууд хүртэлх түрэг-монгол угсааны улсуудын доторх засгийн эрхийн төлөөх тэмцлийг өгүүлэхийг зорьжээ. Зохиогч Монгол, Дундад Ази, Иран, Алтан ордны улс болон тэдгээрийн задралаас үүссэн улс орнуудад дэгдсэн эрх мэдлийн төлөөх дажин, тухайн цагийн нөхцөл байдлыг судлан үзээд өрсөлдөгч этгээдүүдэд хаан сэнтийд залрахын тулд төстэй үндэслэлүүд гарган тавьж, адилавар арга замаар тэмцдэг байсан гэж дүгнэжээ.

63.3(1)

П 65

/НХУУТ-7, ГНОФ-5/

ЭШФ Б 30770-30772



Саруулбуян Ж. Бурхан халдуны сүлдэр / Ред. З.Лонжид, Х.Мэндсайхан; Хян. Н.Ариунтуяа, Л.Энхтуяа; Хавтасны зур. Д.Батхуяг; Цахим бичвэрийг Ж.Тогтох; Диз. Л.Энхтуяа.- УБ., 2021.- 400х.- (Чингис хааны өв, соёлын хүрээлэн).- ISBN 978-99978-781-5-3.

Энэхүү бүтээлд Бурхан Халдун хайрхны тухай, түүнийг эрт урьдаас эхлэн монголчууд үеэс үед эрхэмлэн чанд баримталдаг ёс журмын



дагуу тахисаар ирснийг гүнзгийрүүлэн судалж мөн эзэн Чингисийн тухай дурджээ.

63.3(1)

С 363

ЭШФ Т 25208

Бариянжав П. **Мянгадын түүх** / Ред. На.Сүхбаатар.- УБ.: Соёмбо принтинг, 2021.- 2-р хэвл.

63.3(1-M16)

Б 291



Б. I: XIII-XIX зуун 30-аад он.- 328х.- ISBN 978-9919-24-390-6.

Энэхүү I ботид Ховд аймгийн гарал үүсэл, бүрэлдэхүүн, таархалт; Мянгадын гарал үүсэл, Манж чин улсын эрхшээлийн үеийн Мянгад хошуу; Богд хаант Монгол улс ба ардын засгийн эхэн үеийн мянгад хошуу; Мянгад нарын шашиг шүтлэг; Ховдын мянгадын доторх овог, овгийн үүслийн талаар дурджээ. Тус бүтээл нь Ховд аймгийн Мянгад сум байгуулагдсаны 90 жилийн ойд зориулагджээ.

/НХУУТ-3, ГНОФ-4/

ЭШФ Т 25162-25164



Б. II: XX зуун 1931-2000 он.- 328х.- ISBN 978-9919-24-391-3.

Энэхүү II ботид Мянгад сум байгуулагдсан нь; Зүүнтний алдаатай бодлогын хор уршгийг Мянгад сумынхан туулсан нь; Мянгад сумынхан эрх орноо хамгаалахад хүчин зүтгэж, хувь нэмрээ оруулсан талаар, сонгуулийн тогтолцоо, хөдөө аж ахуйн нэгдлүүд байгуулагдан хөгжсөн (1924-1991) талаар бичигджээ.

/НХУУТ-3, ГНОФ-3/

ЭШФ Т 25165-25167



Дарханы түүхэн товчоон 1961-2021 / Ерөн. ред. А.Түвшинбат; Ред. П.Баярсайхан, Т.Ганболд; Эмхт. Д.Жамбалдорж; Гишүүд Ө.Рагчаасүрэн, Л.Мөнхбаатар; Зөвл. Л.Гүнчин; Эх бэлт. Б.Баярмаа; Хэвлэлийн диз. Т.Банзрагч; Гэрэл зурагчин Г.Энхбаяр; Газарч, хөтөч Б.Баасанжав.- УБ.: Дархан принт, 2021.- 150х.

Эдүгээ 106.0 мянга гаруй хүн амтай, олон улсын авто болон төмөр замын зангилаан дээр байрладаг, төвийн эрчим хүчний системд холбогдсон, дэд бүтэц, аж үйлдвэр эрчимтэй хөгжсөн Монгол Улсын Төвийн Бүсийн Тулгуур Төв болон хөгжиж ирсэн хөгжлийн замнал

түүхийг хураангуйлан эмхтгэж Дархан хотын түүхт 60 жилийн ойд зориулан хэвлүүлжээ.

63.3(1-M19)

Д 381

ЭШФ Т 25242



Минжин Ц. Их Монгол улсын их заргач Шихихутуг= Shihihutug first jurist of great Mongolia / Ред. Д.Оюунцэцэг, Ж.Филип, С.Өөдлөх; Техник ред. Д.Мөнхбаяр; Орч. Г.Ариунболор; Эх бэлт. Б.Батнасан.- 2 дахь хэвл.- УБ.: Мөнхийн үсэг, 2021.- 137х.- ISBN 978-9919-25-645-6.

“Их Монгол улсын заргач Шихихутуг” бүтээлийг түүхэн сурвалж, судалгааны материалд түшиглэн Шихихутугийн амьдрал, үйл ажиллагааг Татар аймаг, Их Монгол улс, Монголын эзэнт гүрний

түүхэн үеүүдэд холбогдуулан бичсэн бөгөөд Монголын төр, эрх зүйн түүх судлаач, оюутан залуус, сонирхогч хүн бүхэнд зориулагдсан болно.

63.3(1)41-8

М 557

ХЗС 22435-22436

Баабар ба бус. **Хэн нь хэн бэ:** Монголчуудын түүхэнд / Г.Баярмагнай, Д.Хүрэлхүү; Ред. Б.Болдбаатар, Б.Цэнддоо; Техник ред. Г.Баярмагнай, В.Уянга, Д.Хүрэлхүү; Эх бэлт. Н.Бямбацогт, Ж.Мөнхсайхан; Хавтасны диз. Н.Бямбацогт.- УБ.: Нэпко, 2021.- 433х.- ISBN 978-9919-511-13-5.



Тус бүтээлд Монгол үндэстний урт удаан түүхийг бүтээлцсэн хүмүүсийн 1200 гаруй хүний товч намтар, уран бүтээлийн талаар дурдсан Монголчуудын түүхэнд Хэн нь Хэн бэ хэмээх лавлах ажээ.

63.3(1)-8

Б 101

/НХУУТ-5, ГНОФ-5/

ЭШФ Т 25147-25149

Цэдэндорж О., Сувдаа Ц. **Үхлийн босго алхсан хүмүүсийн өчил:** Өөрсдийн биеэр туулсан амьдрал, тэмцлийн тэмдэглэл / Эрхлэн хэвл. Ц.Сувдаа; Цахим бичвэр И.Эрдэнэсүвд.- УБ.: Вестлайн, 2020.- 198х.

Орших овогтой Цэдэндоржийг төрийн эсрэг гэмт хэрэгтэн болгосон тухай болон түүний гэр бүл үр хүүхдүүдэд нь хэрхэн нөлөөлсөн тухай бодит түүхийн талаар Энээ ялласан гурван боть, Үхлийн босгоор алхаад гарч чадсан нь НАХ-ын занганаас мултраагүй, Үе дамжуулан мөхөөх социалист араншин гэсэн гурван бүлгийн хүрээнд бичигджээ.

63.3(1)-8

Ц 941

/НХУУТ-3/

ЭШФ Б 30752-30754



Энхжаргал Д. **Бүгд Найрамдах Чех улс:** Түүх, соёл, улс төр, эдийн засаг: Монгол Улс- Бүгд Найрамдах Чех улсын харилцаа / Хян. Ш.Туяа, С.Булгантамир.- УБ.: МУИС-ийн хэвлэх үйлдвэр, 2021.- 391х.- ISBN 978-9919-25-365-3.



Энэхүү бүтээл нь Чехословакийн задралын үе, Бүгд Найрамдах Чех Улс, Монгол Улс Бүгд Найрамдах Чех Улсын харилцааны түүх гэсэн 3 бүлэгтэй. Эхний хоёр бүлэгт Чехийн түүх, түүхэн хүмүүс, соёл, улс төр, эдийн засаг, шинжлэх ухааны хөгжил, боловсрол, хэл, уран зохиол, уран барилга, уран зураг, хөгжим, кино, театр, хувцас, UNESCO-д бүртгэлтэй соёлын биет болон биет бус өв, салбар бүрийн нэртэй хүмүүсийн тухай. Гуравдугаар бүлгээс Монгол-Чехийн 71 жилийн харилцааны талаар мэдлэг хуримтлуулна. Европын түүх соёл, орон судлал, олон улсын харилцаа сонирхдог хэн бүхэнд зориулагджээ.

63.3(4Чех)

Э 66

/НХУУТ-7, ГНОФ-5, ОУХНУС-5/

ЭШФ Т 24784-24786

Жорич А. **Израил инновацийн нууцууд:** Дэлхийг урлан дархалж буй израил хүний бурхан ухаан / Найруулгын ред. Б.Өвгөнхүү; Техник ред. Б.Ариунаа; Орч. Б.Буянт.- УБ.: Евразийн стратеги судлалын хүрээлэн, 2021.- 323х.- ISBN 978-9919-24-988-5.



Энэ ном нь израилчуудын өлсөгсдийг хооллож, өвдөгсдийг эдгээж, ядрагсдыг хамгаалж, цөлийг цэцэгжүүлж буй агуу үйлсийг сурвалжилсан өгүүллүүд багтжээ.

63.3(5ИЗр)+30у

Ж 802

/НХУУТ-5, ГНОФ-5/

ЭШФ Б 30684-30686



Баяр Д. ба бус. **Билэг хааны үнэт эрдэнэс**: 2001 оны малтлага судалгааны үр дүн / Ч.Амартүвшин, А.Энхтөр, Ж.Гэрэлбадрах; Ред. Ц.Баттулга; Гар зур. С.Чинзориг, Г.Гантуяа; Гэрэл зур. Л.Элбэгзаяа, Н.Батдэлгэр, Г.Энхбат, Ким Гуан соб; Эх бэлт. Ш.Гантуул.- УБ.: Адмон принт, 2021.- 140х.- (МУИС-Археологи судалгааны төв, ШУА-Архелогийг хүрээлэн, Монголын Үндэсний Музей).- ISBN 978-9919-504-73-1.

Энэхүү бүтээлийн I бүлэгт Хөх түрэгийн Археологийн дурсгал болох Тахилын онгон, Хүн чулуу, Булш оршуулга; II бүлэгт Хөшөө Цайдамын Археологийн судалгааны талаар, III бүлэгт Үнэт олдворуудын талаар бичсэн ба Билэг хааны тахилын онгоны үнэт эрдэнэсийг нээж олны 20 жил, ШУ-ны салбар үүсэж хөгжсөний 100 жилийн ойд зориулан хэвлүүлжээ.

63.4

Б 48.

/НХУУТ-2/

ЭШФ Т 25238-25240



Монгол улсын нутаг дахь уйгурчуудын археологийн дурсгал / Ред. Л.Эрдэнэболд; Эх бэлт. Т.Нарангуа.- УБ.: Мөнхийн үсэг, 2019.- 307х.- ISBN 978-99978-4-533-7.

Энэхүү бүтээлд Монгол улсын нутгаас илрүүлж, малтаж судалсан 15 хот суурины үлдэц, 10 гаруй язгууртны болон жирийн иргэдийн оршуулгын дурсгалт газар, тахил тайлгын байгууламжийн хэрэглэгдэхүүнд тулгуурлан Уйгурын нийгэм, улс төр, эдийн засаг, гадаад харилцаа, соёл, хот байгуулалт, архитектурын өвөрмөц шийдэл, сэтгэлгээ, гар урлалын хөгжил, ертөнцийг үзэх үзэл, шашин шүтлэг,

аж ахуйн болон оюун санааны хөгжлийн түвшинг тодорхойлжээ.

63.4

М 692

/НХУУТ-4, ГНОФ-3/

ЭШФ Т 25168-25170



Очир А. ба бус. **Монголчуудын үйсэн ном** / О.Иноуэ, Л.Алтанзаяа; Ред. Т.Мацукава; Техник ред. Д.Амарзаяа; Хэвлэлийн диз. Д.Энхнаран.- УБ.: Мөнхийн үсэг, 2019.- 426х.- (UNISCO, Нүүдлийн соёл иргэншлийг судлах олон улсын хүрээлэн).- ISBN 978-9919-21-224-7.

Энэхүү бүтээлийн I бүлэгт Монголчуудын үйсний соёл, үйсний хэрэглээ, үйсний тухай үзэл, ойлголтын талаар, II бүлэгт Тавагчийг улаан; Тавагчийн улааны үйсэн номын зураг, галиг; Хар бух балгас; Хар бухын балганы үйсэн номын зураг, галиг; Галиглалын тухай

бичжээ. Монголчуудын оюуны соёлын бодит байдлын тухай тодорхой мэдээг үйсэн дээрх бичиг дурсгал бидэнд өгч байна.

63.4(1)

О 605

/НХУУТ-4, ГНОФ-3/

ЭШФ Т 25171-25173

Монгол ба бүс нутгийн буган хөшөөний соёл: Эрдэм шинжилгээний каталог Б.І= Deer stone culture of Mongolia and neighboring regions-I / Ж.Гантулга, Н.Баярхүү, Д.Батсүх, Н.Батболд, Г.Энхбаяр, Т.Идэрхангай, Б.Өмирбек, Ц.Төрбат; Ред. Ц.Төрбат; Эх бэлт. Ж.Гантулга, Н.Баярхүү; Хэвлэлийн диз. Б.Баясгалан; Газрын зур. Ж.Гантулга, Ц.Төрбат; Сэргээлт зур. Б.Батцоож.- 2 дахь хэвл.- УБ.: Адмон принт, 2021.- 496х.- (ШУА-Археологийн хүрээлэн).- ISBN 978-9919-9652-0-4.



Энэхүү бүтээл нь Монголын эртний соёл иргэншлийн гол бэлгэдэл дүр бөгөөд монументал урлагийн шилдэг төлөөлөл болох буган хөшөөний нэгэн сэдэвт бүтээл ба анхны бүрэн каталог юм. Тэргүүн ба дэд ботид Монголын 1241 буган хөшөөний товч тодорхойлолт, гар болон өнгөт гэрэл зураг, зарим дурсгалын дэвсгэр зураг багтсан ба энэхүү I ботид Архангай, Баян-Өлгий, Баянхонгор, Булган, Говь-Алтай, Дархан-Уул, Завхан аймгууд багтжээ.

63.4(1)я6

М 692

/НХУУТ-7/

ЭШФ Т 25000-25002

Монгол ба бүс нутгийн буган хөшөөний соёл: Эрдэм шинжилгээний каталог Б.ІІ= Deer stone culture of Mongolia and neighboring regions-II / Ж.Гантулга, Н.Баярхүү, Д.Батсүх, Н.Эрдэнэ-Очир, Г.Энхбаяр, Т.Идэрхангай, Ц.Төрбат; Ред. Ц.Төрбат; Эрдэм шинжилгээний зөвл. Д.Цэвээндорж; Эх бэлт. Ж.Гантулга, Н.Баярхүү; Хэвлэлийн диз. Б.Баясгалан; Газрын зур. Ж.Гантулга, Ц.Төрбат; Сэргээлт зур. Б.Батцоож.- 2 дахь хэвл.- УБ.: Адмон принт, 2021.- 424х.- (ШУА-Археологийн хүрээлэн).- ISBN 978-9919-9652-1-1.



Энэхүү II ботид Өвөрхангай, Сэлэнгэ, Төв, Увс, Улаанбаатар, Ховд, Хөвсгөл, Хэнтий аймгуудын буган хөшөөний каталог багтжээ.

63.4(1)я6

М 692

/НХУУТ-7/

ЭШФ Т 25003-25005

Монгол ба бүс нутгийн буган хөшөөний соёл: Эрдэм шинжилгээний каталог Б. ІІІ= Deer stone culture of Mongolia and neighboring regions-III / Ц.Төрбат, Ж.Гантулга, Н.Баярхүү, Д.Батсүх, Н.Төрбаяр, Н.Эрдэнэ-Очир, Н.Батболд, Ц.Цэлхагарав; Ред. Ц.Төрбат; Эрдэм шинжилгээний зөвл. Д.Цэвээндорж; Эх бэлт. Ж.Гантулга, Н.Баярхүү; Хэвлэлийн диз. Б.Баясгалан; Газрын зур. Ж.Гантулга, Ц.Төрбат.- 2 дахь хэвл.- УБ.: Мөнхийн үсэг, 2021.- 442х.- (ШУА-Археологийн хүрээлэн, МУИС-МСХ).- ISBN 978-9919-9775-0-4.



Энэхүү III боть нь буган хөшөөний судалгааны бүх үндсэн асуудлыг авч үзсэн нэгэн сэдэвт бүтээл болохоос гадна Монголоос шинээр олсон 80 орчим хөшөө ба хил залгаа Евразийн бүс нутгаас илэрч олдсон 340 орчим буган хөшөөдийн эрдэм шинжилгээний каталогийг агуулжээ.

63.4(1)я6

М 692

/НХУУТ-7/

ЭШФ Т 25006-25008



Гонгоржав Г. **Монголчуудын төмөрлөг өв соёл**: Тэргүүн дэвтэр: Алт мөнгө / Ред. Д.Цэвээндорж; Техник ред. Б.Одончимэг, Д.Очирмаа; Эх бэлт. Э.Энэрэл.- УБ.: Адмон принт, 2020.- 384х.- ISBN 978-9919-20-932-2.

Энэхүү бүтээл нь он цагийн хувьд Монгол оронд анх төмөрлөг боловсруулж эхэлсэн хүрэл зэвсгийн үеэс өнөөгийн XXI зууныг хамарсан байна. Мөн монголчуудын уламжлалт алт, мөнгөн эд эдлэлийг хүйгээр нь авч үзэн тэдгээрийг урлахуй арга барил ухаан, хэрэглэдэг багаж зэмсэг, алт мөнгөтэй холбоотой уламжлалт зарим заншил, зан үйл, наргиан наадам зэргийг хүртэл нарийвчлан судалж уг бүтээлдээ оруулжээ.

63.5(1)

Г 543.

/НХУУТ-7/

ЭШФ Б 30729-30731



Гонгоржав Г. **Монголчуудын модон өв соёл**: Эртний үеэс XX зууны эхэн хүртэл.- УБ., 2011.- 494х.- (МУШУА-Археологийн Хүрээлэн).- ISBN 978-99929-61-83-Х.

Энэхүү бүтээлд нүүдэлчин монгол, морьтон монгол, басхүү модчин монгол байсан, эрт дээрээс эдүгээг хүртэлх эдийн хийгээд оюуны, биет болоод биет бус арвин өв соёлыг аль болох цогц дэлгэрэнгүй тусгахыг зорьжээ. Уг бүтээлд модон эм дом, модон тэжээл бордоо, нэн эртний оромж, түр сууц, гэрийн тавилга, уналга тээврийн хэрэгсэл, хашаа хороо, агнуурын хэрэгсэл, бичиг номын хэрэгсэл, хөгжмийн зэмсэг, модон тоглоом, модны сэдэвт монгол ардын дуу, аман зохиол гээд монголчуудын модтой холбоотой арвин их өв соёлын талаар өгүүлжээ.

63.5(1)

Г 543.

/НХУУТ-5/

ЭШФ Б 30732-30734

ЭДИЙН ЗАСГИЙН ШИНЖЛЭХ УХААН



Энхбат Р., Баттүвшин Ч. **Эрэлт нийлүүлэлтийн онол, арга зүй** / Хян. Н.Тунгалаг; Эх бэлт. Ш.Идэрбаяр.- УБ.: МУИС-ийн хэвлэх үйлдвэр, 2021.- 250х.- ISBN 978-9919-25-540-4.

Энэхүү бүтээлд эрэлт, нийлүүлэлтийн онолын үндсийг авч үзэн тэдгээрийн тэнцвэрийн онолтой хэрхэн холбогдох талаар аргазүй талаас нь дэлгэрэнгүй тайлбарласнаас гадна зах зээлийн эрэлт, нийлүүлэлт тэнцүү байх зарчимд тулгуурласан Валрасын тэнцвэр бий болдог тухай тусгажээ.

65.01

Э 66

/НХУУТ-7, ГНОФ-5, БС-5/

ЭШФ Т 24931-24933



Банержи А., Дуфло Э. **Хүнд үеийн эдийн засаг** / Ред. Ж.Хишигжаргал, Д.Очирмаа; Эх бэлт. С.Батжаргал; Англи хэлнээс орч. Б.Дөлгөөн.- УБ.: Адмон принт, 2020.- 420х.- ISBN 978-99973-1-899-2.

Энэхүү номноос та эдийн засгийн тухай дэлгэрэнгүй нарийн ойлголтыг олж авах болно. Уг бүтээлд цагаачлал, худалдаа автоматжуулалт зэргээс үүдсэн ажлын байрны хомсдол, тэгш бус байдал, овог аймгийн тогтолцоо, хоцрогдсон соёл болон цаг уурын

өөрчлөлт гэх мэт эдийн засгийн хүндхэн асуудлуудыг хөнджээ. Мөн уг номын зохиогчид нь 2019 онд Нобелийн шагнал хүртжээ.

65.011

Б 256

/НХУУТ-7, ГНОФ-5/

ЭШФ Т 25033-25035

Намжил Д., Жавхлан Э. **Төрийн санхүү-мөнгөний бодлого** / Хян. Д.Сувдаа.- УБ.: МУИС хэвлэх үйлдвэр, 2021.- 256х.

Энэхүү бүтээлд санхүү мөнгөний бодлогын талаар монгол банкнаас авч хэрэгжүүлдэг нөөцийн нормыг бууруулах арга хэмжээ, эдийн засаг дахь зээл олголтыг нэмэгдүүлэх, мөнгөний нийлүүлэлтэд дэмжлэг өгөх, эдийн засгийн өсөлтөд шууд эерэг нөлөө үзүүлэх мөн эдийн засаг дахь мөнгөний хэмжээ нэмэгдээд инфляци болохоор байвал арилжааны банкнаас төв банкинд хадгалуулах мөнгөний хэмжээг ихэсгэж, инфляцийг зогсоох арга хэмжээ авдаг талаар тусгажээ.

65.26я73

Н 26

/НХУУТ-3, БС-5/

ЭШФ Б 30656-30657



Арнольд Б.Ж. **Олон улсын татварын үндэс** / Орч. М.Энхсайхан, С.Төгсжаргал; Хян. Б.Заяабал, С.Төгсжаргал; Эх бэлт. Ү.Цэндсүрэн; Хавтасны диз. Ц.Түмэнжаргал.- 4 дэх хэвл.- УБ.: Соёмбо принтинг, 2021.- 269х.- ISBN 978-9919-25-694-4.

Энэхүү бүтээлд олон улсын орлогын татварын зохицуулалтыг боловсруулахад баримтлах үндсэн зорилгууд, хил дамнасан ажил гүйлгээг төлөвлөхөд татварын зөвлөхийн гүйцэтгэх үүрэг болон олон улсын татварын төлөвлөлтийн энгийн хэд хэдэн аргуудын жишээг дурдсаны дээр байнга оршин суугч болон оршин суугч бус этгээдийн орлогод татвар ногдуулах нутаг дэвсгэрийг тодорхойлох зохицуулалт, байнга оршин суугчийн гадаад улсад болон дотоодод олсон нийт орлогод татвар ногдуулах үед өөр улс мөн тухайн орлогыг өөрийнх нь нутаг дэвсгэрт бий болсон буюу тухайн улсаас эх үүсвэртэй олсон орлого гэж үзэн орлогын татвар ногдуулсан тохиолдол болон энэ эрсдэлийг бууруулах механизм болон олон улсад татварыг давхардуулан ногдуулах бусад хэлбэр, аливаа улс оршин суугч бус этгээдийн орлогод татвар ногдуулах буюу бусад улсаас эх үүсвэртэй бий болсон орлогод татвар ногдуулахтай холбогдон үүсэх асуудал, олон улсад хамгийн их маргаантай үндэстэн дамнасан аж ахуй нэгжийн татвараас зайлсхийхээс сэргийлэхтэй холбогдуулан компани хооронд үнэ шилжилтийн тохируулга хийх талаар үнэ шилжилтийн дүрмийн асуудал, хяналттай гадаадын компанийн дүрэм, нимгэн капиталжуулалт, хэт өндөр хүүний дүрэм, хоёрдмол шинжтэй аж ахуй нэгж болон санхүүгийн холимог хэрэгсэлд тавигдах татварын онцлогийн талаар дурджээ.

65.261.4(0)

А 764

/БС-5, НХУУТ-3/

ЭШФ Т 25254-25255





Байгууллага судлал: Онол - үзэл баримтлал: Б.И= Organization studies: Theories - concepts / Хян. Х.Батцэнгэл, Ш.Бат-Эрдэнэ, С.Будням ба бус.; Ерөнхий нарийн бичгийн дарга П.Оюун-Эрдэнэ; Эх бэлт. Д.Оюун.- УБ.: Адмон принт, 2021.- 536х.- ISBN 978-9919-9590-2-9.

МУЭИС-ийг төгссөн 30 гаруй эрдэмтэд орчин үеийн байгууллага судлалын чиглэлээр туурвисан “Байгууллага судлал” Онол ~ Үзэл баримтлал цуврал номын I боть хэвлэгдэн гарлаа. Уг бүтээл нь байгууллагын хөгжлийн орчин үеийн онол, үзэл баримтлал, чиг хандлага, байгууллагын менежмент, байгууллагын соёл, ногоон хөгжил, чанарын болон байгууллагын менежмент, бүтэц зохион байгуулалт, чанарын болон хяналтын менежмент, санхүү, байгууллагын төрөл зэрэг агуулгыг багтаасан байна.

65.290-2

Б 179

/НХУУТ-4, ГНОФ-3, ОУХНУС-3/

ЭШФ Т 25039-25041



Байгууллагын зан төлөв хичээлийн кейс, дасгал, тестийн хураамж / Г.Цэрэн, Ө.Зулбаяр, Б.Болор, Б.Пүрэвдорж; Хян. Г.Цэрэн, Б.Болор.- УБ.: Нью Индиго, 2021.- 287х.- ISBN 978-9919-25-443-8.

Уг гарын авлагад бүлэг тус бүрийн сэдвүүдэд тохирсон сонирхолтой кейс, дасгал, сорилууд болон өөрийгөө шалгах тестүүдийг багтаасан ба ашигласан материалын хувьд сүүлийн үеийн гадаадын эх сурвалжууд болон сурах бичгүүдээс орчуулж эмхэтгэсэн болно.

65.290-2

Б 179

/НХУУТ-3, БС-10, ОУХНУС-5/

ЭШФ Т 24858-24859



Цэрэн Г. Байгууллагын зан төлөв / Хян. Б.Болор.- 2 дахь хэвл.- УБ.: Нью Индиго, 2021.- 688х.- ISBN 978-9919-25-443-8.

Зохиогч энэхүү бүтээлдээ 2014 онд гаргасан өмнөх хэвлэлийнхээ агуулгыг нэмж баяжуулан "Бие хүний хувийн онцлог шинжүүд ба зан төлөвийн ялгаатай хэлбэрүүд", "Ажлын байран дахь сэтгэл хөдлөл", "Багаар ажиллах нь", "Эрх мэдэл ба түүний ажлын байран дахь нөлөө" зэрэг сэдвүүдийг шинээр нэмэн 3 бүлэг 18 сэдэвтэйгээр уншигч та бүхэндээ хоёр дэх хэвлэлээ хэвлүүлжээ.

65.290-2я73

Ц 969 /НХУУТ-7, ХЗС-3, ГНОФ-15, БС-10, Цахим, ОУХНУС-5/ ЭШФ Т 24815-24817



Ленчиони П. Багийн таван бэрхшээл: Амжилттай багийг хэрхэн бүрдүүлэх вэ? = The five dysfunctions of a team: A leadership fable / Ред. Ж.Хишигжаргал, Д.Очирмаа; Орчуулгын ред. М.Бямбасайхан; Англи хэлнээс орч. Г.Энх-Амгалан; Эх бэлт. С.Батжаргал.- УБ.: Адмон принт, 2021.- 212х.- ISBN 978-99973-1-903-6.

Патрик Ленчионигийн энэхүү ном нь манлайллын тухай, бодит амьдралын жишээтэй нэгэн адил сонирхолтой, сэтгэл татам байдлаар бичигджээ. Энэ номд гарч буй үйл явдлын хүрээнд багууд, тэр ч байтугай хамгийн шилдэг багийн ажиллагааг доголдуулахад хүргэдэг таван гол хүчин зүйлийг гаргаж ирсэн юм. Тэрээр эдгээр саад бэрхшээлийг даван туулах, эв нэгдэлтэй,

үр дүнтэй багийг бүрдүүлэхэд ашиглаж болох хүчирхэг загвар, хэрэгжүүлэх алхмуудыг тоймлон харуулжээ. Мөн тэрээр багийн онцгой удирдагч, гишүүн байхыг хичээдэг бүх хүнд зориулж, энгийн боловч гайхамшигтай түүхийг өгүүлжээ.

65.290-3

Л 439

/НХУУТ-3, ГНОФ-3, ОУХНУС-3/

ЭШФ Б 30663-30665

Тебекин А.В. **Логистик**: Сурах бичиг / Хөрв. П.Даш; Орчуулгыг шүүн тунгаасан П.Батаахүү, Д.Оюунцэцэг, Д.Байгальмаа; Эх бэлт. М.Амартайван.- УБ.: Хөх Монгол принтинг, 2021.- 356.- ISBN 978-9919-25-034-8.



Уг сурах бичиг нь логистикийн үүрэг, зорилт, логистикийн хөгжлийн хүчин зүйл ба хандлага, логистикийн зарчмууд, мэдээллийн логистик, худалдан авалтын логистикийн механизм, үйлдвэрлэлийн үйл явцын логистик, үйлдвэрлэл дэх материалын урсгалын зохион байгуулалт, үйлдвэрлэлийн үйл явцыг цаг хугацаагаар зохион байгуулах, түгээлт, борлуулалтын логистик, урсгал нөөцийн логистик, тээврийн логистик, тусламж үйлчилгээний логистик, логистикийн удирдлагын зохион байгуулалт зэрэг асуудлуудыг багтаасан логистикийн тулгамдсан асуудал бүхий материалыг агуулж байна.

65.42я73

Т 30

ЭШФ Б 30764-30765

Будням С. **Орчин үеийн Монголын эдийн засгийн бүтцийн математик шинжилгээ** / Ред. С.Будням; Эх бэлт. Ү.Цэндсүрэн; Хавтасны диз. Ц.Түмэнжаргал.- УБ., 2021.- 200х.- ISBN 978-9919-25-217-5.



Уг бүтээлд Монголын эдийн засгийн системийн бүтэц, салбар хоорондын балансын онол, хэрэглээний орчин үеийн хөгжил орчин үеийн Монголын зах зээлийн эдийн засгийн системийн салбар хоорондын хамаарлын шинжилгээ, салбар хоорондын балансын өргөтгөсөн хандлагыг Монгол улсын хөгжлийн төлөвлөлт прогноз-аналитик шинжилгээнд ашиглах арга зүйн талаар тусгажээ.

65.9(1)-2

Б 708

БС 11392-11396

Гөлгөө Ж. **Эдийн засгийн гадаад харилцаа ба аюулгүй байдлын асуудлууд** / Хян. Б.Батхишиг.- УБ.: Тоонотпринт, 2021.- 157х.- ISBN 978-9919-24-657-0.



Доктор Ж.Гөлгөө энэхүү судалгааны бүтээлдээ Монголын үндэсний нөхөн үйлдвэрлэлийн онцлог, түүнд гадаадын зээл тусламж, олон улсын худалдаа, гадаадын шууд хөрөнгө оруулалтын гүйцэтгэж буй үүрэг, тэрчлэн тэдгээрээс үүдэж үндэсний эдийн засгийн аюулгүй байдалд учирч болох сорилт, эрсдэлүүдийг шинжин, үнэтэй дүгнэлт, санал зөвлөмж дэвшүүлжээ.

65.9(1)-98

Г 601

/НХУУТ-7, ОУХНУС-10/

ЭШФ Б 30658-30660

УЛС ТӨРИЙН ШИНЖЛЭХ УХААН



Бэвир М. **Засаглал: Тун товчхон танилцуулга=Governance: A very short introduction** / Орч. Т.Ариунсанаа; Техник ред. В.Уянга; Хавтасны диз. Н.Бямбацогт; Эх бэлт. Д.Цэрэндулам.- УБ.: Мөнхийн үсэг, 2021. - 144х.- ISBN 978-99978-51-32-1.

“Засаглал” гэж юу болох, Засгийн газраас ямар ялгаатай, “Сайн засаглал”, “Муу засаглал” гэж юуг хэлдэг вэ?, Засаглалыг хаана юунд хэрэглэж болох тухай Засаглалын онол болоод тэдгээр нь нийгмийн зохицуулалт, дүрэм журмын хэв маягтай хэрхэн холбогддог, Засаглал нь хувийн хэвшил, олон нийт, олон улсын харилцаанд яаж нөлөөлж байдаг талаар мэргэжлийн түвшинд тун товчхон тодорхой бичигдсэн часхийсэн атлаа авсаархан, уншигчдын халаасны толь болно гэж энэ номын талаар судлаачид тодорхойлжээ.

66.0

Б 920

/НХУУТ-4, ГНОФ-4/

ЭШФ Б 30715-30716



Милль Ж.С. **Эрх чөлөөний тухай: Монсудар нийгмийн ухаан: №6** / Ред. Б.Дөлгөөн, П.Сарангарав; Эх бэлт. С.Батжаргал; Англи хэлнээс орч. Н.Лхагважав.- УБ.: Монсудар, 2021.- 191х.- ISBN 978-99973-1-736-0.

Жон Стюарт Миллийн Эрх чөлөөний тухайд номонд түүний бүх зохиол бүтээлтэй нь ялангуяа Лессе-фейрийн үндэслэл ба хязгаар буюу хөндлөнгөөс үл оролцохын зарчмыг авч үзсэн түүний Улс төрийн эдийн засгийн зарчмуудын талаар тусгажээ.

66.0

М 544

/НХУУТ-7, ГНОФ-5/

ЭШФ Б 30675-30677



Паршев А. **Орос яагаад Америк биш вэ?** / Орч. Д.Ганцэцэг; Хян. Ц.Чингүнбат; Эх бэлт. О.Болор; Хавтасны диз. Э.Мөнхтөр.- УБ.: Соёмбо принтинг, 2021.- 436х.- ISBN 978-9919-9723-3-2.

Андрей Паршев Оросын улс төрийн зохиолч юм. Түүний "Орос яагаад Америк биш юм бэ" номонд системийн шинжилгээний аргыг хэрэглэж, олон төрлийн судалгаа, тоо баримтаар баяжуулсны үндсэн дээр Оросын нийгмийн мөн чанарыг эдийн засаг, эдийн засгийн газар зүй, түүх, улс төр, сэтгэл зүй, харьцуулсан эдийн засаг зэрэг олон шинжлэх ухааны зааг дээр авч үзсэн нь ихээхэн үр ашигтай шийдэл болжээ. Мөн нийгмийн нэг байгуулал, үзэл суртал-улс төрийн нэг системтэй байсан учраас тэдний ардчилал шинэчлэл, шилжилт, өмч хувьчлал, гадаад худалдааны сүйрэл, үйлдвэрлэлийн уналт, нийгмийн давхраажил, ялгарал, сэтгэлгээний хоцрогдол, зөрчил, олигархийн ноёрхолын талаар тусгажээ.

66.0

П 18

/НХУУТ-7, ГНОФ-5/

ЭШФ Б 30681-30683

Фукуяма Ф. **Танигдахуй**: Нэр төрийн хэрэгцээ ба гомдлын улс төр / Ред. С.Баяраа, Б.Болдбаатар; Техник ред. В.Уянга; Орч. Д.Баярхүү; Хавтасны диз. Н.Бямбацогт; Эх бэлт. Д.Цэрэндулам.- УБ.: Нэнко, 2020.- 242х.- ISBN 978-9919-500-62-7.



Энэхүү номдоо зохиолч, нийтийн сэхээтэн Фрэнсис Фукуяма танигдахуйн үзэл санааны хөгжлийг Платоноос эхлээд, Локк, Руссогоор дамжуулан, феминизм хийгээд орчин үеийн хүйсийн улс төр хүртэл судалжээ. Тэрээр нэгэн том анхааруулгыг хүргэхийн тулд энэхүү түүхийг сөхсөн нь юу гэвэл хэрэв бүгдээрээ хүний нэр төрийн талаар түгээмэл ойлголттой болохгүй бол хүн төрөлхтөн бид мөнхийн зөрчил тэмцэл үргэлжилж болзошгүй талаар дурджээ.

66.0

Ф 942

/НХУУТ-7, ГНОФ-5/

ЭШФ Б 30693-30695

Улс төр судлалын бүдүүвчийн цомог / Хян. Д.Лүндээжанцан; Эх бэлт. Э.Эрдэнэтуяа.- 3 дахь хэвл.- УБ., 2020.- 182х.- ISBN 978-99978-0-060-2.



Энэхүү гарын авлага улс төрийн шинжлэх ухааны суурь ухагдахуунуудад хамаарагдах сэдвийн агуулга, үндсэн асуудлууд, тэдгээрийн томъёоллыг ангилан бүлэглэж оруулсны дээр улс төр судлалын дотоод, гадаадын олон эрдэмтэн судлаачдын зохиол бүтээлийг харьцуулан судалж оруулж өгчээ. Уг бүтээл нь нийгмийн ухаан, түүний дотор төр, нийгмийн удирдлага, философи, социологийн мэргэжлээр сурч буй оюутан суралцагсад, эрдэм шинжилгээ, судалгааны ажилтан нарт чухал хэрэглэгдэхүүн болох болно.

66.0я7

У 314

ХЗС 22439

Миллер Д. **Улс төрийн гүн ухаан**: Тун товчхон танилцуулга / Хян. Ч.Өнөрбаяр; Техник ред. Х.Наранцацрал; Орч. О.Очиржав; Хавтасны диз. Н.Бямбацогт; Эх бэлт. Ж.Мөнхсайхан.- УБ.: Мөнхийн үсэг, 2021.- 123х.- ISBN 978-99973-938-9-0.



Энэхүү бүтээлд эрх мэдэл, ардчилал, эрх чөлөө, шударга ёс, феминизм, мультикультурализм, үндэс угсаа зэрэг улс төрийн философийн гол ойлголтуудын талаар өгүүлнэ. Зохиогч бээр төр бидний амьдралын чанарт үнэхээр нөлөөлдөг үү? Төр эрх мэдлээ субъектуудаа албадан хэрэгжүүлэх шаардлагатай юу? Ардчилалд энгийн иргэд ямар үүрэг гүйцэтгэдэг вэ? зэрэг асуултуудад хариулахыг зорьжээ. Мөн улс төр яагаад бидэнд хэрэгтэй эсэх хийгээд төр бидний амьдралын аль хэсэгт оролцож болохгүй талаарх асуудлыг ч хөндөж тавьсан байна.

66.1

М 544

/НХУУТ-4, ГНОФ-4/

ЭШФ Б 30719-30720



Снайдер Т. **Дарангуйлал**: ХХ зууны хорин сургамж / Ред. С.Баяраа; Техник ред. В.Уянга; Орч. Д.Баярхүү; Хавтасны диз. Н.Бямбацогт; Эх бэлт. Д.Цэрэндулам.- УБ.: Нэпко, 2020.- 107х.- ISBN 978-9919-500-72-6.


Энэхүү бүтээлд Захирагдах гэж бүү яар; Инстүүцүүдээ хамгаал; Нэг намын тогтолцооноос болгоомжил; Дэлхийн нэр хүндийн төлөө хариуцлага үүр; Мэргэжлийн ёс зүйг санаж яв; Хагас цэрэгжсэн бүлгүүдээс болгоомжил; Хэрэв зайлшгүй зэвсэглэх ёстой бол бодолтой бай; Бусдаас ялгар; Эх хэлдээ энэрэнгүй ханд; Үнэнд итгэ; Эрэн сурвалжил; Хүнтэй харцаараа харилцаж, яриа өд; Амьд улс төрийг хэрэгжүүл; Хувийн амьдралтай бай; Сайн үйл хэрэгт хувь нэмэр бол; Бусад орон дахь үзэл бодол нэгтнээсээ суралц; Аюултай үгсийг анирд; Төсөөлөхийн аргагүй зүйл болох үед тайван бай; Эх оронч бай; Чадах чинээгээрээ зоригтой бай гэсэн ХХ зуунаас авах хорин сургамжийг өнөөгийн нөхцөл байдалтай уялдуулан толилуулжээ.

66.1

С 49

/НХУУТ-7, ГНОФ-5/

ЭШФ Б 30690-30692



Миног К. **Улс төр: Тун товчхон танилцуулга Politics: A very short introduction** / Орч. Т.Ариунсанаа; Техник ред. Б.Болдбаатар, В.Уянга; Хавтасны диз. Н.Бямбацогт; Эх бэлт. Д.Цэрэндулам.- УБ.: Мөнхийн үсэг, 2021.- 119х.- ISBN 978-9919-500-31-3.


Тус бүтээлд эртний сонгодог эринээс ХХ зуун хүртэлх хугацаанд улс төр хэрхэн хувьсан өөрчлөгдөж хөгжсөнийг тэнцвэртэйгээр тайлбарлахыг зорьжээ. Эхлээд Герег, Ромын сонгодог эринийг авч үзэн иргэншил, иргэн гэж хэнийг хэлэх, эх оронч үзэл гэж юу болохыг тайлбарлажээ. Дараагийн бүлэгт Христийн шашин ба хувьч үзэл, орчин үеийн төр, хүчний тэнцвэр, улс төрийн идэвхи, намууд, үзэл номлол, ардчилал, үзэл суртал болон ХХI зуунд улс төр ямар байж болох талаар дурдсан.

66.1(0)

М 561

/НХУУТ-4, ГНОФ-4/

ЭШФ Б 30711-30712



Оюун-Эрдэнэ Л. **Алсын хараа**. – УБ.: Нэпко, 2021.

66.1(1)

О-634

Монгол Улсын Ерөнхий сайд Л.Оюун-Эрдэнэ нь Монгол Улсын Засгийн газрын Хэрэг Эрхлэх Газрын даргаар ажиллах хугацаандаа “Алсын хараа 2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогыг боловсруулах ажлын хэсгийн ахлагчаар ажиллаж, бүтэн жилийн хугацаанд 1500 гаруй эрдэмтэн судлаачид, төрийн албан хаагчид, олон улсын байгууллагын шилдэг мэргэжилтнүүдтэй хамтран ажилласан. 2020 оны хавар УИХ-аар батлагдсан уг хөгжлийн бодлогыг суурь есөн зорилго, хөгжлийн 47 зорилттойгоор 10 жилийн хугацаатай гурван үечлэлээр тодорхойлсон. Уг ном нь тус урт хугацааны хөгжлийн бодлогын баримт бичгийг өөрийн үзэл бодлоор хураангуйлан бичсэн бүтээл юм.

Б. 1: Таны орон зайг тэлнэ. - 117х.- ISBN 978-9919-500-81-8.

ЭШФ Т 25075



Б.2: Азийн хүлэг улс / Ред. А.Амарсайхан, Д.Түмэн-Өлзий; Мэргэжлийн ред. Э.Болормаа; Зураач С.Цогтбаяр; Диз. Н.Бямбацогт; Гэрэл зур. Ж.Батбаатар, Х.Түшиг; Зөвл. Л.Саянаа, Д.Амгаланбаатар, Б.Солонгоо.- 3 дахь хэвл.- 119х.- ISBN 978-9919-500-80-1.

ЭШФ Т 25074



Б. 3: Азийн хүлэг улс алсын хараа-2050 / Ред. В.Батцэцэг, Д.Түмэн-Өлзий, Д.Батбаяр ба бус.; Зөвл. П.Цэцэгбадам, П.Зохихсүрэн; Диз. Н.Бямбацогт, Ц.Энхгэрэл; Гэрэл зур. Ж.Батбаатар, Б.Бямба-Очир, Б.Уугансүх ба бус.; Хавтасны зур. Б.Чадраабал.- 128х.- ISBN 978-9919-500-85-6.

ЭШФ Т 25076

Теодулу С.З., Рой Р.К. **Төрийн захиргаа**: Тун товчхон танилцуулга / Орч. Т.Ариунсанаа; Техник ред. Б.Болдбаатар, В.Уянга; Хавтасны диз. Н.Бямбацогт; Эх бэлт. Д.Цэрэндулам.- УБ.: Мөнхийн үсэг, 2021.- 116х.- ISBN 978-99978-51-50-5.



Даяаршлын эринд төрийн захиргаанд тулгамдаж буй том сорилтуудын талаарх практик үзэл хандлагууд ба төрийн үйлчилгээний хувьчлал, тагнуул, тандалт зэрэг маргаантай асуудлуудыг товч тайлбарлаж, мөн төрийн захиргааны үүсэл, хөгжил, цаашид хэрхэн хувьсан хөгжиж буй талаар өгүүлжээ.

66.2

Т 359.

/НХУУТ-4, ГНОФ-4/

ЭШФ Б 30717-30718

Монголын төр, нийгмийн нэрт зүтгэлтэн Дарамын Төмөр-Очир / Эрхл. Л.Дашням; Эмхт. А.Жамбал, Г.Ануудар.- УБ.: Адмон, 2021.- 443х.- ISBN 978-9919-25-538-1.



Тус бүтээлд ШУА-ийн Философийн хүрээлэн, Монголын Философийн Холбооноос зохион байгуулсан “Дарамын Төмөр-Очир: амьдрал, үйл ажиллагаа” сэдэвт эрдэм шинжилгээний хурлын илтгэл; шавь нар, хамтран зүтгэж байсан төр нийгмийн зүтгэлтнүүд, эрдэмтдийн дурсамж; хурал зөвлөгөөнд хэлсэн үг; нийгэм, улс төрийн үйл ажиллагааных нь талаарх эрдэмтэн судлаачдын эрдэм шинжилгээний өгүүлэл; 1990-ээд оны эхэн үеийн сонины нийтлэл, ярилцлага; архивын баримт, гэрэл зургийн цомог бүхий нийт зургаан бүлгээс бүрдэж байна. Төр, нийгмийн зүтгэлтэн, академич, Монголын анхны мэргэжлийн философич Д.Төмөр-Очирын тухай доктор, профессор Ц.Балхаажав, академич Ш.Бира, академич Ч.Далай, Ерөнхий сайд Д.Бямбасүрэн, Монгол Улсын гавьяат эмч Б.Сагараажав, доктор профессор Н.Дангаасүрэн, орчуулагч Х.Лхамдорж, Б.Бирваа, түүхч Д.Цолмон, Ардын уран зохиолч Б.Лхагвасүрэн, урлаг судлалын ухааны доктор профессор С.Цэрэндорж, түүхийн ухааны доктор С.Идшинноров нарын 20 жилийн өмнө бичсэн дурсамжууд нийтлэгдсэн болно.

66.3(1)8

М 695

/НХУУТ-12/

ЭШФ Т 25138-25140



Бэлтон К. **Путиний гар хөлүүд**: КГБ Оросыг буцааж аваад дараа нь өрнө рүү өнгийв / Ред. Б.Батбаяр; Техник ред. Н.Нандинчимэг; Орч. Т.Ариунсанаа; Эх бэлтг. Д.Цэрэндулам; Хавтасны диз. Н.Бямбацогт.- УБ.: Нэпко, 2021.- 527х.- ISBN 978-9919-511-16-6.

Энэ бол Путин, түүний эргэн тойронд гар хөл болсон хүмүүс болон сүүлийн 30 жилийн орчин үеийн Орос улсын тухай бичигдсэн хамгийн шилдэг, зоримог эрэн сурвалжилгад тулгуурласан бүтээл юм.

66.3(2Орос)8
Б 935

/НХУУТ-7, ГНОФ-5/

ЭШФ Т 25141-25143



Бенедиктов К.С. **Хар хун**: Дональд Трампын улс төрийн намтар / Ред. Б.Оюунчимэг; Орч. И.Рэнчинханд; Эх бэлтг. Э.Болдбаатар.- УБ.: Хөх судар принтинг, 2020.- 328х.- ISBN 978-9919-20-733-5.

Уг ном "Дональд Трамп улс төрийн намтар" гэсэн давхар тодотголтой. Номын гол баатар Дональд Трамп улстөрч биш, залуугаасаа хийсэн ажил нь бизнес байсан бөгөөд улмаар томоохон бизнесмен, тэрбумтны 2016 оны 11 сарын 8-наас өмнөх буюу АНУ-ын Ерөнхийлөгчийн сонгуулийн дүн гараагүй, компанит ажил нь ид байх, өөрөөр хэлбэл Трампыг Нэгдсэн улсын Төрийн тэргүүн хараахан

болоогүй байх үеийн тухай өгүүлсэн байна.

66.3(7АНУ)8
Б 46

/НХУУТ-3, ГНОФ-3/

ЭШФ Б 30638-30639



Монгол улсын тусгаар тогтнол ба ерөнхий сайд Цэнгэлтийн Жигжиджавын нийгэм эдийн засгийн шинэтгэл: Эрдэм шинжилгээний хурал / Хян. Да. Эрдэнэбат, Ш.Цогтоо; Эх бэлтг. Д.Оюун; Диз. Д.Пүрэвсүрэн.- УБ.: Адмон принт, 2020.- 148х.- ISBN 978-9919-20-315-3.

Энэхүү бүтээлд ХХ зууны Монголын төрийн нэрт зүтгэлтний нэг Ц.Жигжиджавын амьдрал, үйл ажиллагаа төдийгүй тухайн үеийн Монголын нийгэм эдийн засаг, улс төрийн амьдралын тухай шинэ сонирхолтой баримт, санал дүгнэлтүүд дэвшүүлсэн эрдэм

шинжилгээний хурлын илтгэлүүдийг болон хэлэлцүүлгийн явцад хэлсэн үгээ бичгээр ирүүлсэн хүмүүсийн сэтгэгдлийг эмхэтгэн оруулжээ.

66.3(1)8
М 692

ЭШФ Б 30810-30812



Болд Р. **Бүрэн эрхээ хязгаарлуулсан тусгаар тогтнол** / Хян. Ц.Батбаяр; Эх бэлтг. Д.Цэрэндулам; Хавтасны диз. Н.Бямбацогт.- УБ.: Нэпко, 2021.- 210х.- ISBN 978-9919-500-78-8.

Энэхүү бүтээлд Богд хаант Монгол улсын Гадаад явдлын яамны тэргүүн сайд Б.Цэрэндорж, VIII Богд Жибзундамба нар Хятадын цэргийн дипломат шахалтанд хэрхэн орж, цэрэг оруулахыг зөвшөөрсөн (1918.09.03-нд морьт хороо, 1919.08.19-нд, мөн 9 сард 3000 хүний бүрэлдэхүүнтэй бригадын 2 хороо, 10.29-нд бяцхан Сүйтэй хамт 8-р хороо иржээ) болон Улаан армийн морьт дивизион

(багахан хүч) 1928 он хүртэл Монголд байсан талаар тусгаснаас гадна Их гүрнүүдийн хавчилт зэргийн талаар өгүүлэх болно.

66.4

Б 547

/НХУУТ-5, ГНОФ-5/

ЭШФ Б 30773-30775

Төмөрхүлэг Т. **Орос, Монгол, Хятад:** Улс төр, дипломатын ойллого / Техник ред. Н.Нандинчимэг; Эрхл. Ж.Болдбаатар, Х.Бэхбат; Хавтасны диз. Н.Бямбацогт; Эх бэлт. Д.Цэрэндулам.- УБ.: Нэпко, 2021.- 366х.- ISBN 978-9919-511-09-8.



Энэхүү бүтээл XX зууны Монгол улс - хоёр их хөршийн түүхэн харилцааны явцыг онол- арга зүйн шинэ хандлага, Монгол, Орос, Францын архивын сан хөмрөг, олон орны дипломат баримт бичгүүд, Монголын болоод гадаадын түүхч, нийгмийн ухааны эрдэмтдийн судалгаан дээр үндэслэн туурвижээ. Ингэхдээ түүх бичлэгийн хэвшмэл бус, шинэ эсрэг арга зүйг баримтлан өөрийн гэсэн өнгө аясаар туурвисан байна.

66.4(0)

Т 587

/НХУУТ-4, ГНОФ-3, ОУХНУС-5/

ЭШФ Т 25030-25032

Монгол-Хятадын соёл, шинжлэх ухааны харилцаа (1949-1965): Тэргүүн боть.- УБ.: Бемби сан, 2021.- 433х.- ISBN 978-9919-9577-3-5.



Эрдэмтэн судлаачдын баг Монгол Улсын Үндэсний төв архив, Гадаад харилцааны төв архивын сан хөмрөгүүдэд баримтын судалгаа хийж, холбогдох 700 гаруй баримт бичгийг илрүүлснээс 229 баримтыг нь сонгож авч, энэхүү эмхэтгэлийн үндсэн болон тайлбар хэсэгт оруулжээ. Хэвлэгдэн гарч буй эдгээр баримтаас 200-гаад нь анх удаа эрдэм шинжилгээ, судалгааны эргэлтэнд орж байгаа тул Монгол-Хятадын соёлын харилцааг цаашид гүнзгийрүүлэн судлах судлаачдад чухал хэрэглэгдэхүүн болох ач холбогдолтой юм. Энэхүү баримт бичгийн эмхэтгэл нь Монгол, Хятадын харилцааны эхэн үеийн нэгэн чухал чиглэл болох соёл, шинжлэх ухааны харилцаа, хамтын ажиллагааны эхлэл, өрнөл, хөгжлийг харуулсан түүхэн эх сурвалж – архивын баримтуудыг агуулсан анхны төрөлжсөн бүтээл болж байгаа бөгөөд ШУА байгуулагдсаны 60 жилийн ойд зориулснаараа онцлог юм.

66.4(1+5Хят)

М 692

ЭШФ Т 25077-25078

SIRPA FORUM: Эрдэм шинжилгээний хурлын эмхэтгэл № 4: Ковид-19 дэлхийн шинэ дэг журам / Ерөн. ред. С.Баттулга; Эмхт. Ж.Баттөр, Б.Мөнх-Өлзий, С.Оюунсүрэн, Б.Баттогтох.- УБ.: Удам соёл, 2021.- 538х.- (МУИС-ОУХНУС).- ISBN 978-9919-504-44-1.



Уг бүтээлд хоёр хөрш, гуравдагч хөрш, бүс нутаг болон Монгол улсын гадаад бодлого, аюулгүй байдал, эдийн засаг, нийгмийн харилцаа, нийтийн удирдлагын хөгжил энэ хүрээнд тулгамдаж буй асуудал шийдвэрлэх арга зам болон улс орны хөгжилд тулгарч буй зангилаа асуудлууд, сорилт болон шинэ чиг хандлагын талаар тодорхой тусган харуулжээ.

66.4я43

S 36

ЭШФ Т 25219-25220



Монгол улсыг хүрээлэн буй геополитик, геостратегийн гадаад орчин: Өнгөлөн далдлалт, төөрөгдүүлэлт, бодит байдал, хашлага давах боломж / Эрхлэн хэвл. С.Баттулга; Эх бэлт. Д.Оюун.- УБ.: Адмон принт, 2021.- 282х.- (МУИС-ОУХНУС).- ISBN 978-9919-25-311-0.

Энэхүү бүтээлд дэлхий дахинд даяаршил эрчимжихийн зэрэгцээ улс үндэстнүүд дангааршихыг эрмэлзэх болсон өнөө цаг үед хоёр их гүрний дунд шахагдан орших Монгол улс үндэстэнд тусгаар тогтнол, эрх чөлөөгөө бататган бэхжүүлэх асуудал, Covid-19 цар тахлын энэ хэцүү цаг үе тулгарахад Монголчууд түүнийг ямар арга ухаанаар, хэрхэн даван туулж байв, мөн олон улс үндэстэнтэй хэрхэн харилцаж, өөрсдийгөө хэрхэн хүлээн зөвшөөрүүлж, тусгаар тогтнолоо хэрхэн хамгаалж бэхжүүлж ирсэн талаар тусгажээ.

66.4(1)

Б 60

ЭШФ Б 30803-30804



Крик Б. Ардчиллын тухай: Тун товчхон танилцуулга / Хян. Ч.Өнөрбаяр; Техник ред. Х.Наранцацрал; Орч. Д.Оргил; Хавтасны диз. Н.Бямбацогт; Эх бэлт. Ж.Мөнхсайхан. - УБ.: Мөнхийн үсэг, 2021.- 136х.- ISBN 978-9919-22-213-0.

Энэхүү бүтээлд ардчилал бол нээлттэй мэтгэлцээн, итгэн үнэмшүүлэх хийгээд харилцан буулт хийх зарчимд тулгуурлагдгаас гадна ардчилсан тогтолцоо нь алдаа дутагдал гаргасан эсвэл хэрэгцээгүй болсон төр засгийн бодлого, улс төрчдийг тогтмол, тайван замаар халж өөрчлөх боломж олгох замаар нийгмийн болон үе хоорондын шинэчлэлийн талаар тусгажээ.

66.63

К 824.

/НХУУТ-4, ГНОФ- 4/

ЭШФ Б 30713-30714

ТӨР ЭРХ, ХУУЛЬ ЦААЗЫН ШИНЖЛЭХ УХААН



Эрх зүйн шинэтгэл ба Монгол улсын хөгжил: Олон улсын эрдэм шинжилгээний хурлын эмхэтгэл / Ред. Д.Оюунцэцэг; Эмхт. Б.Нармандах.- УБ., 2021.- 319х.

Энэхүү эрдэм шинжилгээний хурлын эмхэтгэлд УИХ-аас 2019 онд Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан нэмэлт өөрчлөлт болох Монгол улсын нийгэм, улс төрийн ардчилсан тогтолцооны төлөвшил, хөгжилд онцгой ач холбогдолтой, засаглалын хяналт, тэнцлийг хангаж, Засгийн газрын тогтвортой байдал, парламентын хариуцлагыг нэмэгдүүлж, ард түмний засаглах эрх, төрийн эрх мэдлийг хуваарилах зарчмыг бодитой хэрэгжүүлэх, хүний эрх, эрх чөлөөг баталгаажуулах, шударга шүүхийг төлөвшүүлэх, Монгол Улсын иргэн улс орныхоо, байгалийн баялгийнхаа жинхэнэ эзэн байх эрх зүйн үндсийг бүрдүүлэх, нийгмийн шударга ёсыг тогтооход түүхэн ач холбогдолтой эрх зүйн шинэтгэлийн талаар тусгажээ.

67.0я43

Э 81

ХЗС 22437-22438

Болдбаатар Ж., Лүндээжанцан Д. **Монгол улсын төр, эрх зүйн түүхэн уламжлал** / Хян. И.Дашням; Хэвлэлд бэлт. С.Банзрагч, С.Энх-Амгалан; Эх бэлт. П.Номинцэцэг; Хавтасны диз. Э.Доржханд.- 3 дахь хэвл.- УБ.: Соёмбо принтинг, 2021.- 427х.- ISBN 978-9919-24-223-7.



Эл бүтээл нь монголын төр, эрх зүйн хөгжлийг гүн ухаан, түүх, хууль зүйн шинжлэх ухааны бэлчир зангилаан дээр авч үзэж, асар их түүхэн баримт сэлтийг нягтлан боловсруулж, үндэслэл гаргалгаа хийхийг хичээсэн үнэ цэнтэй бүтээл болжээ. Энэхүү номонд Монгол Улсын төр, эрх зүй үүсэн хөгжиж ирсэн түүхэн үйл явц, уламжлалыг манай ард түмний соёл иргэншлийн үе шат бүрээр өгүүлэн, шинжлэх ухааны даацтай дүгнэлт гаргалгаа хийсэн байна. Уг бүтээл нь нэмж засварласан гурав дахь хэвлэл бөгөөд монгол улсын төр, эрх зүйн түүхийн бүх үе шатыг хамарч, төр ба эрх зүйн түүхийг хамтатган багтаасан анхны ном байсан, эдүгээ ч хэвээр байна.

67.3

Б 547

ХЗС 22409-22411

Эртний хуулиуд - Ойрх Дорнод = Ancient legal codes - middle east / Санаачлагч, зохицуулагч М.Хатанзориг; Редакцийн зөвл. Ж.Бямбаа, Л.Нарангэрэл, Ц.Минжин, Н.Жамбалжав; Орч. М.Хатанзориг, Д.Одон, Л.Нарангэрэл, Ц.Байгаль; Тайлбар лавлагаа М.Хатанзориг, О.Батсүх; Техникийн ажилтан Ё.Өсөхбаяр, Б.Цогзол; Эх бэлт. Б.Батнасан; Эмхт. М.Хатанзориг.- УБ.: Мөнхийн үсэг, 2021.- 499х. ISBN 978-9919-25-826-9.



Цаг хугацааны хувьд хамгийн эртний бичмэл хуулиуд ойрх дорнодын үржил шимт саран хөндий (fertile crescent), Месопотами, Анатолийн газар нутгаас олддог. Тэр дундаа дэлхийд анхдагч гэгдэх Ур-Наммугийн хууль бидний сайн мэдэх Ромын арван хоёр самбарын хуулиас 1600 гаран жилийн өмнө батлагджээ. Энэхүү эмхэтгэлд тус хуулиас эхлэн эртний Сүмер, Вавилон, Ассир, Хиттитийн хуулиудыг орчуулан, тайлбар зүүлт хийж оруулжээ.

67(533)

Э 802

ХЗС 22417-22419

Роффэр М.Х. **Дэлхийн эрх зүйн түүх = The law book** / Ред. Б.Болдбаатар; Техник ред. В.Уянга, Б.Эрдэнэбаяр; Редакц О.Билэгт, Б.Даваажав, Ц.Долгормаа; Орч. Г.Баясгалан, Д.Одбаяр, Д.Сугар; Хавтасны диз. Н.Бямбацогт; Эх бэлт. Д.Цэрэндулам.- 2 дахь хэвл.- УБ.: Нэпко, 2020.- 526х.- ISBN 978-9919-500-68-9.



Хаммурабийн эртний хуулиас өнөөгийн Олон улсын Эрүүгийн шүүх хүртэлх дэлхий эрх зүйн түүхийн 250 онцлох үйл явдлыг багтаасан Америкийн Нью-Йоркийн хуулийн сургуулийн профессор Майкл Рофферийн “Дэлхийн эрх зүйн түүх” хэмээх номыг доктор Д.Сугар, эрх зүйч Г.Баясгалан, Д.Одбаяр нар орчуулан НЭПКО хэвлэлийн газраас уншигчдаа хүргэж байна. Уг бүтээл нь шинжлэх ухааны хялбаршуулсан хэлбэртэй бөгөөд эрх зүйч, мөн түүхийг сонирхогч хэн бүхний сонирхолд нийцэх түүхэн үйл явдлыг баримттай, энгийн хэллэгээр дүрслэн өгүүлж, холбогдох зураг, бичиг баримтыг хавсаргажээ.

67.3(0)

Р 797

/ХЗС-5, НХУУТ-4, ГНОФ-3/

ЭШФ Т 25202-25204



Сарантуяа Ц. **Үндсэн хуулийн процессын эрх зүй** / Эх бэлт. Д.Оюун.- 2 дахь хэвл.- УБ.: Адмон принт, 2021.- 238х.- ISBN 978-9919-25-581-7.

Энэхүү бүтээлд Үндсэн хуулийн цэцэд холбогдох хуулиудад эдүгээ хүртэл орсон нэмэлт, өөрчлөлтийг бүхэлд нь харгалзан тусгаснаас гадна номын агуулгыг Үндсэн хуулийн цэцэд маргаан шийдвэрлэсэн сүүлийн үеийн зарим жишээгээр баяжуулсан болно. Ингэхдээ номын анхны хэвлэлд жишээ болгон толилуулсан Цэцийн шийдвэр, баримтын заримыг хэвээр үлдээсний дээр үндсэн хуулийн шүүхийн онол, практикийг судлах явцад хүрсэн зарим дүгнэлт, тулгамдсан асуудал, процессын шинжлэх ухааны суурь ойлголтуудын талаар давхар тусгажээ.

67.400.1

С 339

ХЗС 22357-22366



Чимид Б. **Бүгд найрамдах Монгол Ард Улсын захиргааны эрх зүй: Ерөнхий анги** / Эрхл. Д.Баянбилэг, Ч.Сайнсанаа; Хавтасны диз. Э.Энхсанаа; Эх бэлт. Ц.Ганганцэцэг.- УБ., 2021.- 314х.- ISBN 978-9919-24-570-2.

Б.Чимид багшийн "Цагаан ном" гэж алдаршсан "БНМАУ-ын Захиргааны эрх зүй (Ерөнхий анги)" сурах бичгийг "Чимид сан"-аас эрхлэн хэвлүүлжээ. Зохиогчийн энэ алдартай сурах бичгийн суурь нь тэр үеийн хууль зүйн сэтгүүлд түүний нийтлүүлсэн өгүүлүүд болжээ.

Уг бүтээлд захиргааны эрх зүйн үндсэн ойлголт, зарчмуудын талаар тусгажээ.

67.401(1)я73

Ч 628

ХЗС 22440-22442



Иргэний эрх зүй: Ерөнхий анги / Техник ред. Б.Оюун-Эрдэнэ; Эх бэлт. Б.Марал-Эрдэнэ.- УБ.: Мөнхийн үсэг, 2021.- 336х.- ISBN 978-9919-9811-1-2.

Энэхүү бүтээлд иргэд хоорондын өдөр тутмын харилцаанаас эхлээд аж ахуй, бизнесийн үйл ажиллагааг зохицуулах суурь зохицуулалтууд, тэдгээрийн уялдаа холбоог илэрхийлэх нийтлэг үндэслэл, зарчим, онолын үзэл санааны хүрээнд тайлбарлах арга зүйг хуулийн сургуулийн оюутан, эрх зүй судлаачид, төдийгүй хууль, эрх зүйг сонирхогч хэн бүхэнд танилцуулахад чиглэсэн иргэний эрх зүйн гарын авлага юм.

67.404я7

И 788

ХЗС 22425-22429



Оюунбадам Р. **Эмэгтэйчүүд ба хорих ял**: Онол, арга зүй, практик / Ерөн. ред. С.Нарангэрэл; Ред. Б.Мөнх-Эрдэнэ; Зөвлөх ред. Д.Баярсайхан.- УБ.: Би Си Ай, 2021.- 339х.- ISBN 978-9919-24-469-9.

Энэхүү бүтээлээр эрх зүйн онолыг практикт хэрэгжүүлэх аргачлалыг гарган тавих түүнчлэн онол сургаал нь бодит байдалд хэрхэн оновчтой тусгагдаж байгаа эсэхийг нарийн тогтоохыг зорьжээ. Уг бүтээлд эмэгтэйчүүдийн хорих ялын талаарх онол, практик, амьдралын эгзэгтэй агшин мөч, эмэгтэйчүүдэд хорих ял эдлүүлэх уламжлал болон орчин үеийн чиг хандлагыг эрүүгийн эрх зүйн төдийгүй ял эдлүүлэх эрх зүйн үүднээс шинжлэх ухааны үндэслэлтэйгээр дүн шинжилгээ хийн ял эдлүүлэх дэглэмийн эрх зүйн зохицуулалтыг монгол улсын болон олон улсын хэмжээнд харьцуулж, дэлхий

үүднээс шинжлэх ухааны үндэслэлтэйгээр дүн шинжилгээ хийн ял эдлүүлэх дэглэмийн эрх зүйн зохицуулалтыг монгол улсын болон олон улсын хэмжээнд харьцуулж, дэлхий

нийтийн жишиг, үнэт зүйлс талаас нь нээн илрүүлж, гаргасан нь үнэхээр жинтэй, үр дүнтэй бүтээл болсныг харуулж байна.

67.408

О-634.

/ХЗС-10, НХУУТ-4, ГНОФ-3/

ЭШФ Б 30828-30830

Батсүх О. **Эрүүгийн эрх зүй**: Ерөнхий анги / Ред. Ж.Бямбаа; Эх бэлт. Б.Батнасан; Хавтасны диз. М.Хатанзориг.- УБ.: Мөнхийн үсэг, 2021.- 279х.- ISBN 978-9919-25-898-6.



Зохиогч бүтээлдээ гэмт хэрэг, ялтай холбоотой онол, практикийн асуудлуудыг болон тодорхой төрлийн гэмт хэргүүдийн үндсэн бүрэлдэхүүний объектив болон субъектив шинж, ял хүндрүүлэх, онц хүндрүүлэх нөхцөл байдлууд, тодорхой гэмт хэрэг бүр бусад төсөөтэй гэмт хэргүүдтэй хэрхэн харьцах, тэдгээрийг ялган зүйлчлэх асуудлыг тал бүрээс нь иж бүрэн авч үзжээ. Мөн өөрийн болон бусад орны түүхэн эх сурвалжуудаас олон арван ишлэл авч оруулжээ.

67.408я73

Б 34

ХЗС 22430-22434

Брүүкс Г. **Авлигын криминологи**: Онолын чиг хандлага / Ред. Б.Батзориг, О.Мөнхбат, Д.Отгонжаргал; Орч. А.Амармэнд; Эх бэлт. Б.Тамир.- УБ.: Урангар пресс, 2021.- 338х.- ISBN 978-9919-25-260-1.



Энэхүү бүтээлд авлигын гэмт хэрэг гарах шалтгаан нөхцлийг зөв тогтоож, цаашид гарахаас урьдчилан сэргийлэх, зөв арга барил, стратегиар үр дүнтэй тэмцэх, авлига гэж юу вэ, авлигыг хэрхэн хэмжих вэ, манай улсад авлигын нөхцөл байдал бодитоор ямар байна вэ мөн авлига нь зөвхөн төрийн албаны асуудал биш болох, авлигыг хэмжих нь тийм ч амар хялбар хэрэг биш, авлига байгууллагын бүтэц дотор шингэж хэвшмэл зүйл болж болдог тухай маш олон шинэлэг ойлголтууд багтжээ.


67.51

Б 685.

/НХУУТ-7, ГНОФ-5, ХЗС-5/

ЭШФ Б 30748-30750

Мөнх-Эрдэнэ Б. **Гэмт хэрэг судлалын онол= Criminology theory** / Ред. П.Баянбаатар; Зөвлөх ред. Р.Оюунбадам; Эх бэлт. Г.Энхдэлгэр.- УБ.: Өнгөт талст, 2021.- 296х.- ISBN 978-9919-25-920-4.



Нийгэм дэх гэмт хэргийн шинж чанарыг судалдаг олон онолууд бий. Энэхүү бүтээлд тэрхүү онолуудын харьцуулалт, ялгааг гаргаж, хууль бус үйлдлийн үндэс болоод түүнээс олон нийт урьдчилан сэргийлэх, хариуцлага хүлээлгэх асуудалд хэрхэн анхаарах талаар тусгасны дээр өнөөгийн нийгмийн сэтгэлгээнд гарч буй олон сөрөг өөрчлөлт, тэдгээрийн шалтгааныг судлах нь гэмт хэргээс урьдчилан сэргийлэх нөхцөл болж өгдөг төдийгүй хувь хүний харгис хэрцгий, сувдаг шунахай зан төлөв байдал, нийгмийн дундах ажилгүйдэл, ядуурал, архидалт, хүчирхийлэл, ялгаварлах үзэл гэх зэрэг гэмт хэргийн шалтгааныг судлах талаар тусгажээ.

67.51

М 816

ХЗС 22420-22424

ЦЭРГИЙН ШИНЖЛЭХ УХААН



Баян-Эрдэнэ Д. Газрын тосны бүтээгдэхүүний гал түймрийн аюулгүй байдал, унтраах арга зүй, эрсдэлийн үнэлгээний аргачлал / Хян. Б.Баяржаргал; Диз. Р.Батболд; Эх бэлт. Ж.Өнөрмаа.- УБ.: Соёмбо принтинг, 2013.- 185х.- ISBN 978-99962-2-407-268.

Газрын тос, газрын тосны бүтээгдэхүүний гал түймрийн аюулгүй байдал, унтраах арга зүй, эрсдэлийн үнэлгээ, гал түймрээс хэрхэн урьдчилан сэргийлэх, хохирол багатай унтраах, газрын тосны бүтээгдэхүүний агуулахын эрсдэлийн үнэлгээг хэрхэн хийх аргачлалын талаар уг гарын авлагад тусгажээ.

68.9

Б 38

ЭШФ Т 25118



Гамшгаас хамгаалах бодлого, стратеги / Хян. О.Үржин.- УБ.: Удам соёл, 2020.- 273х.- ISBN 978-9919-24-577-1.

Энэхүү бүтээлд гамшгаас хамгаалах бодлого, стратегийн онолын үндэс, тэдгээрийн харилцан хамаарал, тэдгээрийг боловсруулах арга зүй зэргийн шинжлэх ухааны үндэслэлийг системийн хандлагаар тодорхойлсны зэрэгцээ боловсруулсан онол, арга зүй дээрээ тулгуурлан гамшгаас хамгаалах бодлого, стратегийн өнөөгийн байдлын шинжилгээг өнгөрсөн, одоо, ирээдүй гурван цагийн хэлхээсэнд гүйцэтгэж, тэдгээрийн шинэчлэлийн чиглэл, үндэслэлийг

дэлхий нийтийн чиг хандлагад нийцүүлэн үндэсний онцлогоо харгалзан тодорхойлж, онол, арга зүй, практик хэрэглээний логик уялдаа холбооны талаар тусгажээ.

68.9+20.1

Г 209

ЭШФ Т 25100-25101



Гамшгаас хамгаалах цагаан ном 2020 / Хян. Ц.Ганзориг, Д.Сэржмядаг; Эх бэлт. Ч.Наранцацрал.- УБ.: Гамшиг судлалын хүрээлэнгийн хэвлэх үйлдвэр, 2021.- 334х.

Тус номонд гамшгаас хамгаалах хууль эрхзүйн орчин, шинэчлэл, гамшгаас хамгаалах үйл ажиллагаа, гадаад, дотоод хамтын ажиллагаа, галын аюулгүй байдал, улсын нөөц, хүмүүнлэгийн тусламж, газар хөдлөлтийн аюулаас урьдчилан сэргийлэх, гамшгаас хамгаалах судалгаа, шинжилгээний ажил болон гамшгаас хамгаалах үйл ажиллагаан дах төсөв, хөрөнгө оруулалтын талаарх танилцуулга зэргийг багтаажээ.

68.9

Г 209

ЭШФ Т 25104-25105



Даш П. Улсын нөөц, түүний удирдлага: Судалгааны ажлын тайлан / Шүүн тунгаасан Д.Оюунцэцэг, Д.Байгальмаа; Эх бэлт. М.Амартайван.- УБ.: Хөх монгол, 2021.- 260х.- ISBN 978-9919-25-094-2.

Уг судалгааны ажилд улсын нөөц, түүний удирдлагын тухай онол, арга зүйн үндэс улам боловсронгуй болж сайжрах, практик амьдрал дээр шалгагдан үр дүнгээ өгсөн зүйл нь амьдралд хэрэгжин, улам

боловсронгуй болж, ашиг тусаа өгөөгүй зүйл нь гээгдэн хоцрох мөн улсын нөөц, түүний удирдлагыг боловсронгуй болгох практик алхамын талаар тусгажээ.

68.9

Д 392

ЭШФ Б 30760-30761

Судалгааны ажлын эмхэтгэл 2020 / Хян. Д.Сэржмядаг; Эмхт. Д.Нарантуяа.- УБ.: Удам соёл, 2021.- 418х.- ISBN 978-99978-3-354-9.

Энэхүү судалгааны ажилд гамшгаас хамгаалах чиглэлээр хийгдсэн 5 судалгааны үр дүн, Боловсрол, шинжлэх ухаан, спортын яамны захиалгат "Гамшгаас хамгаалах бодлого ба стратеги" суурь судалгааны төслийн хүрээнд тус хүрээлэнгээс зохион байгуулсан "Гамшгаас хамгаалах бодлогын хөгжил, шинэчлэл" сэдэвт эрдэм шинжилгээний бага хурлын илтгэл, хурлаас гарсан зөвлөмжийг эмхэтгэн оруулжээ.

68.9я43

С 701

/НХУУТ-3/

ЭШФ Т 25114-25115



Содномрагчаа Д. **Монгол орны гамшгийн атлас** / Ерөн. ред. Т.Бадрал; Хариуцлагатай ред. П.Даш, Д.Нарангэрэл, Н.Орших; Редакцийн зөвлөлийн дарга Д.Алтангэрэл; Редакцийн зөвлөлийн гишүүд Б.Пүрэвням, Д.Сэржмядаг, Д.Баян-Эрдэнэ ба бус.; Газрын зургийн ред. Д.Нарангэрэл, Н.Орших; Диз. Д.Содномрагчаа; Хэвлэлийн диз. Б.Баясгалан.- УБ., 2020.- 36х.- ISBN 978-99978-3-326-6.


Энэхүү бүтээлд дэлхийн уур амьсгалын өөрчлөлтөөс шалтгаалан цаг агаар хэт хуурайшиж, ой, хээрийн түймэр, ган зуд болон уламжлалт бус аюулын тохиолдол нэмэгдэж байгаа талаар тусгажээ.

68.9(1)+20.1

С 522

/НХУУТ-3/

ЭШФ Т 25102-25103



ШИНЖЛЭХ УХААН СУДЛАЛ

МУБИС-ийн түүхийн тэнхимийн эрдэм шинжилгээний сэтгүүл Т. XXII: Fasciculus 1-10 Acta historica / Зөвлөлийн дарга Ж.Гэрэлбадрах; Нарийн бичгийн дарга Н.Сүхбаатар; Гишүүд Р.Сабиров, Т.Мэй, Б.Оюунбилиг ба бус.; Эрхл. Ж.Гэрэлбадрах; Эх бэлт. Ү.Цэндсүрэн; Хавтасны диз. Ч.Бямбасүрэн.- УБ.: Соёмбо принтинг, 2021.- 193х.- ISBN 978-99978-871-6-0.

МУБИС-ийн Түүхийн тэнхимээс эрхлэн гаргадаг эрдэм шинжилгээний сэтгүүлийн энэ дугаарт угсаатан судлал, дундад үеийн түүх, ойрхи үеийн түүхэнд холбогдох судалгааны өгүүлэл, илтгэлүүд оржээ.

72+63.4

А 19

/ЛавФ-1/

ЭШФ Т 25244-25246





Ази судлал: Олон улсын эрдэм шинжилгээний долоодугаар хурал= The 7th International conference on Asian Studies / Эрхл. Ш.Эгшиг; Эх бэлт. Н.Гэрэлмаа; Сэтгүүлийн зөвлөл Н.Гэрэлмаа, Ц.Онон, Д.Ундрах ба бус.- УБ.: Удам соёл, 2021.- 444х.- ISBN 978-99973-73-19-9.

Энэхүү олон улсын эрдэм шинжилгээний хурлын эмхэтгэлд Хэл шинжлэл үсэг бичиг судлал, Түүх археологи олон улс судлал, Утга зохиол соёл судлал, Философи, Боловсрол судлал заах арга зүй сэдвийн хүрээнд 50 гаруй эрдэмтэн судлаачдын судалгаа шинжилгээний ажлууд багтжээ.

72

А 341

ЭШФ Т 25205-25207



Дуламрагчаа Т. Судалгааны ажлын үндэс / Хян. Б.Баярмаа; Эх бэлт. Б.Чимгээ; Хавтасны диз. Б.Марал-Эрдэнэ.- УБ.: Адмон принт, 2021.- 187х.- ISBN 978-9919-25-076-8.

Тус гарын авлага нь их дээд сургуулийн оюутан, магистрант докторантууд болон залуу судлаачдад зориулагдсан судалгааны түгээмэл 20 аргын тухай, судалгааны ажлын 8 төрлийг хэрхэн бичих талаар болон судлаачийн ёс зүй, баримтлах зарчим судалгааны ажилд тавигддаг нийтлэг шаардлагуудын тухай бичигдсэн өргөн агуулга бүхий онцлог бүтээл юм.

72

Д 642

/НХУУТ-3, ГНОФ-5/

ЭШФ Т 25133-25134



Отгоннасан В. МУИС-ийн профессорын эрдмийн өв цуврал: Эрдэм шинжилгээний бүтээлийн эмхэтгэл / Эмхт. Ц.Болд, Ч.Тамир; Эх бэлт. Э.Уранбилэг; Эрхл. Ж.Лхагвадэмчиг; Диз. У.Билэгт-Од.- УБ., 2021.- ISBN 978-9919-504-55-7.

Энэхүү бүтээлд академич Ванданы Отгоннасангийн социологийн чиглэлээр туурвисан эрдэм шинжилгээний өгүүлэл, илтгэл, бүтээлүүдээс дээжлэн эмхэтгэжээ.

72+60.56

М 692

Б.І: Социологи ба боловсрол.- 336х.

/НХУУТ-5, ГНОФ-5/

ЭШФ Т 25183-25187

Б.ІІ: Монголын нийгэм ба олон нийтийн санал бодол.- 332х.

/НХУУТ-5, ГНОФ-5/

ЭШФ Т 25188-25192



Үндэсний даван туулах чадвар: Монгол улс= National resilience: Mongolia / Ерөн. ред. С.Баттулга; Эмхт. Эрхлэн хэвл. С.Баттулга.- УБ.: Удам соёл, 2021.- 137х.- ISBN 978-9919-504-71-7.



Уг академик хэлэлцүүлэгт Монгол улсын их, дээд сургууль, судалгааны байгууллага, шинжлэх ухааны холбогдох салбар (байгаль, нийгэм, хүмүүнлэгийн чиглэл, хүрээлэн буй орчин, тогтвортой хөгжил, антропологи, аюулгүй байдал, онцгой байдал, эрсдэлийн менежмент, нийтийн удирдлага, бусад)-ын нэр хүндтэй судлаач, профессор, шинжээч урилгаар оролцож, өөрийн судалгааны салбар чиглэлийн хүрээнд илтгэл, саналаа хэлэлцүүлэг.

72

У 825

ЭШФ Т 25221-25222

Эрдэм судлалын бичиг / Эмхт. Г.Төртогтох; Хян. Д.Сандагсүрэн; Эх бэлт. П.Номинцэцэг; Хавтасны диз. Э.Доржханд.- УБ.: Соёмбо принтинг, 2020.- 291х.



СИТИ их сургуулийн эрдмийн зөвлөл багш, оюутнуудынхаа эрдэм шинжилгээ, судалгааны бүтээлүүдээс сонгон нийтэлдэг "Эрдэм судлалын бичиг" сэтгүүлийнхээ ээлжит дугаарыг хэвлүүлэн гаргажээ. Энэ дугаарт Бизнесийн удирдлага, Урлаг гоо зүй, Сэтгүүл зүй, Улс төр үзэл бодол, Хэл зүй боловсрол судлал, Аялал жуулчлал, Хууль эрх зүй, Барилга архитектур хувцасны дизайн сэдвийн хүрээнд 20 гаруй эрдэмтэн судлаачдын эрдэм шинжилгээ судалгааны ажлууд багтжээ.

72

Э 739

ЭШФ Т 25234-25235

БОЛОВСРОЛ. СУРГАН ХҮМҮҮЖҮҮЛЭХ УХААН

Төмөр-Очир С. Дэлхийн боловсролын харьцуулсан судалгаа: АНУ, Их Британи, Герман, Франц, Япон, ОХУ, Финлянд, Монголын жишээн дээр / Ред. Б.Жадамба; Эх бэлт. Д.Чимэдцэрэн, Б.Банзрагч.- УБ.: ЗГ-ийн хэвлэх үйлдвэр, 2020.- 290х.- ISBN 978-9919-20-302-3.



Дэлхийн тэргүүлэх хөгжилтэй орнуудын боловсролын өнөөгийн байдлыг судалж өөрийн орны боловсролын тогтолцоо, сургалтын төлөвлөгөө, хичээлийн хөтөлбөр, түүнийг хэрэгжүүлэх арга барилын юуг нь яаж өөрчлөн шинэчлэхийг тогтоож Монгол хүүхдэд тохирсон, Монгол хөрсөнд ургаж, өөрсдөө бүтээсэн Монгол боловсролтой болох явдал чухал болж байгаатай уялдуулан энэхүү боловсролын харьцуулсан судалгаа бүхий гарын авлагыг уншигч та бүхэндээ толилуулжээ.

74(0)я7

Т 587

/НХУУТ-2/

ЭШФ Т 25135-25137




Тогтвортой хөгжлийн зорилгын төлөөх боловсролыг суралцахуйд интеграцчилах арга зүй.- 2 дахь хэвл.- УБ.: Битпресс, 2021.

Энэхүү багц номонд 1972 оноос хойших дэлхий нийтийн түвшин дэх ТХ ба ТХБ-ын түүхэн замнал, үйл явцын өрнөл, тэдгээрийн зорилго, агуулга арга хандлагын интеграцыг НҮБ-ын тулгуур баримт бичгүүдэд үндэслэн тоймлож бүхэлд нь харах, улмаар түүний Монгол Улсад тусгалаа олж, боломж бүрдсэнээр тогтвортой байдлын асуудалд хандахдаа тухайн цаг үе, үйл явдлаар хязгаарлахгүй, өмнөх туршлага, сургамждаа тулгуурлан үйл явцын динамик тасралтгүй шинжийг хадгалан бүхэл бүтэн, дотоод саланги чанарынх нь нэгдлийг голлон барьж, алсын хараатайгаар сэтгэн бодож, үйлдэн гүйцэтгэх нь үр өгөөжтэй болохын чухлыг дурджээ.

74.26я7

T 441



Бага боловсрол: Багшийн гарын авлага.- 256х.- ISBN 978-9919-9714-1-0.

ЭШФ Т 25079-25082



Суурь боловсрол: Багшийн гарын авлага.- 420х.- ISBN 978-9919-9714-2-7.

ЭШФ Т 25083-25086



Бүрэн дунд боловсрол: Багшийн гарын авлага.- 340х.- ISBN 978-9919-9714-3-4.

ЭШФ Т 25087-25090

Дэлхий нийтийн түвшинд болон монгол улс дахь ТХ ба ТХБ-ын хөгжлийн замнал, өрнөл: Хөтөч ном. - 264х.- ISBN 978-9919-9714-0-3.

ЭШФ Т 25091-25094

СЭТГҮҮЛ ЗҮЙ



Баатархуяг А. **Нэрээ гологсод** / Ред. Г.Уянга; Эх бэлт. Н.Түвшинбат; Хавтасны диз. Э.Мөнхтөр.- УБ.: Соёмбо принтинг, 2020.- 404х.- ISBN 978-9919-20-477-8.

Зөвхөн вакум орон зайд л та өөрийн хүссэн өв тэгш сайн хүн байх бололцоотой. Харин түүнээс гармагц бусдын аливаа үйлдэлд, хариу үйлдэл үзүүлэгч, магадгүй сэргэлдэгч байхаас аргагүй билээ. Амьдарна гэдэг тоглоом биш ч амьдрал хариу үйлдэл шаардсан нөхцөлүүд, өрсөлдөөн тэмцэл, дүрэм, өөр өөрийн зорилго тээж явдаг талаар уг бүтээлд өгүүлсний дээр олон арван өгүүллээсээ шилж 30

гаруй өгүүлэл хэвлүүлжээ.

76.01

Б 111

/НХУУТ-7, ГНОФ-5/

ЭШФ Б 30666-30668

Уянга Г. **Цаг нь болохоор** / Ред. А.Баатархуяг; Эх бэлт. Н.Түвшинбат; Хавтасны диз. Э.Мөнхтөр.- УБ.: Соёмбо принтинг, 2020.- 392х.- ISBN 978-9919-20-478-5.

Энэхүү бүтээлд 40 гаруй өгүүлэл хэвлүүлсний дээр энэ бүхнийг нэгтгэн гаргасан нь бидний амьдарч байгаа түүхэн энэ цаг үеийн тухай цэгцтэй ойлголт авахад хожмын үеийнхэнд баримт, материал болон үлдэх билээ.



76.01

У 711

/НХУУТ-7, ГНОФ-5/

ЭШФ Б 30669-30671

Бодлын солбицол "Үнэн" сонин доторх сонин: (1991.7.9-1991.12.28) / Ерөн. ред. Б.Ганболд, Б.Ерэнтэй, Р.Энхбат; Техник ред. Д.Очирмаа; Эх бэлт. Б.Баясгалан.- УБ.: Монсудар, 2020.- 398х.- ISBN 978-99973-1-912-8.

Энэхүү бүтээлд Үнэн сонины 1991.07.9-1991.12.28-ны хооронд хэвлэгдсэн нийтлэлүүд багтжээ.



76.02

Б 533

/НХУУТ-7, ГНОФ-5/

ЭШФ Т 25042-25044

Баасансүрэн Т. **Сэтгүүл зүйн шүүмж судлал, телевизийн хөтөлбөрийн судалгаа** / Хян. Б.Наминчимэд; Номын эх бэлт. Н.Батсүх, Н.Тэлмүүн; Эхийг хэвлэлд бэлт. Ц.Чагнаадорж, Ч.Сумд.- УБ., 2021.- 359х.

Энэхүү бүтээлд шүүмж судлалын өгүүлүүд, хөрөг нийтлэл, ярилцлага, Монголын тэргүүлэх телевизүүдийн үйл ажиллагаа, TV9 телевизийн нэвтрүүлэг, хөтөлбөрүүдэд хийсэн шинжилгээ зэрэг багтжээ.



76.032

Б 109

ЭШФ Б 30826-30827

МУЗЕЙН АЖИЛ

Музей судлал: Том. XXII-I, Fasc. 1-25 / Ерөнхий эрхлэгч Л.Жаргал; Нарийн бичгийн дарга Д.Мөнхтоогоо; Гишүүд Д.Бумаа, Ч.Амартүвшин, Б.Баяртөр ба бус.; Эх бэлт. Б.Сарнай, М.Мөнгөнцэцэг.- УБ.: Соёмбо принтинг, 2021.- 280х.

Монголын Үндэсний Музейгээс "Музей судлал" нэрийг дахин сэргээж, музей судлалын онолын үзэл баримтлал, музейн түүх, цуглуулгыг судалгааны эргэлтэнд оруулж, монгол оронд музей судлалыг хөгжүүлэх зорилгоор бие даасан эрдэм шинжилгээний сэтгүүл бэлтгэн хүргэжээ. Судалгааны сэтгүүлийн энэ дугаарт музей судлалын онол музейн түүх, соёлын өв цуглуулгын судалгаа, хадгалалт хамгаалалт зэрэг өргөн хүрээнд хийж буй судалгааны үр дүнгийн талаар тусгажээ.



79.1я5

М 865

ЭШФ Т 25247-25248

ХЭЛ БИЧГИЙН ШИНЖЛЭХ УХААН



Хэрэглээний хэл шинжлэл: Б.В(20), Дэвт.1-22 / Ерөн. ред. Д.Төмөртоогоо; Нарийн бичгийн дарга О.Шинэбаяр; Эрхл. Б.Баяртуяа; Гишүүд Г.Гэрэлмаа, Г.Томтогтох, Н.Мөнхцэцэг ба бус.- УБ.: Соёмбо принтинг, 2020.- 220х.- ISSN 2524-0951.

Тус дугаарт профессор О.Адъяагийн товч намтар, эрдэм шинжилгээний өгүүлэл багтсанаас гадна Монгол улс, БНХАУ-ын эрдэмтэн судлаачдын нэр томъёоны онол, арга зүй, хэлний хэрэглээ болон хэрэглээний хэл шинжлэлийн бусад асуудалтай холбогдуулан бичсэн 21 эрдэм шинжилгээний өгүүлийг нийтэллээ. Мөн ШУА-ийн

Хэл зохиолын хүрээлэнгийн Хэрэглээний хэл шинжлэлийн салбарын эрдэм шинжилгээний ажилтнуудын бичсэн шинэ номыг танилцуулж байна.

81я43

X 931

ЭШФ Т 24893



Одонтор Ш., Баттөгс М. Монгол хэлний гучтын тайлбар толь.- УБ.: Цагаан бамбарууш, 2021.- 510х.

Энэхүү тайлбар толь нь 250 000 холбоо үг, хэлц үгийн санг багтаасан дэлгэрэнгүй тайлбар толь юм. Уг тольд монгол хэлэнд нэн эрт орж монголжсон харь үг (лам, ном, саван, судар, жижүүр, цонх, лууван гэх мэт)-ийг монголжсон хэлбэрээр нь оруулжээ.

81.2М-4


О-197

Б. I: А-О.- 510х.

ЭШФ Т 25048-25050

Б. II: Ө-Я.- 1032х.

ЭШФ Т 25051-25053



Цогзолмаа Г. Хятад-Англи-Монгол хэлний 1000 өгүүлбэр: Ариутган шүүсэн Г.Гэрэлмаа; Хавтасны диз. Б.Лхагвасүрэн; Эх бэлт. Г.Хулан.- 4 дахь хэвл.- УБ.: Соёмбо принтинг, 2020.- 268х.- ISBN 978-99962-75-25-8.

Энэхүү бүтээлд 1000 өгүүлбэрийг хятад-англи-монгол хэлээр зэрэгцүүлэн тусгаснаас гадна монгол бичгийг албан хэрэгцээнд сэргээн хэрэглэж байгаатай холбогдуулан оюутан залуусыг өөрийн өв соёл болсон монгол бичгийг хэрэглэхэд дөхөм болгох зорилгоор

монгол бичгээр хадмаллан оруулжээ.

81.2Хят-2

Ц 754

/НХУУТ-5/

ЭШФ Б 30735-30737

УРАН ЗОХИОЛ

Түүвэр зохиол.- УБ.: Соёмбо принтинг.

84(1)

T 821

Б.І: Дашдоржийн Нацагдорж / Эмхт. Г.Цогзолмаа.- 3 дахь хэвл.- 2021.- 168х.- ISBN 978-99978-1-992-5.

Дашдоржийн Нацагдорж (1906-1937 он) нь Монголын орчин үеийн утга зохиолыг үндэслэгч, зохиолч, яруу найрагч, нийгмийн нэрт зүтгэлтэн, орчуулагч түүний алдарт бүтээлүүд болох "Миний нутаг", "Алс газар сурахаар явагч" яруу найраг, "Шувуун саарал", "Хөдөө талын үзэсгэлэн" богино өгүүллэг, "Учиртай гурван толгой" жүжгийн зохиол зэрэг нь уг бүтээлд багтжээ.



/НХУУТ-4/

ЭШФ Т 25054-25056

Б.ІІ: Цэндийн Дамдинсүрэн / Эмхт. Г.Цогзолмаа; Хян. Г.Цогзолмаа; Эх бэлт. А.Нямлхагва; Хавтасны диз. Б.Эрдэнэбулган; Техник ред. П.Эрдэнэбаатар.- 2018.- 282х.- ISBN 978-99978-4-201-5.

Уг бүтээлд Ардын уран зохиолч, академич Цэндийн Дамдинсүрэнгийн туурвисан "Хоёр цагаан юм", "Гологдсон хүүхэн", "Бух Гомбо", "Солийг сольсон нь", "Хэлдэг гурав хийдэг ганц", "Буурал" үргэлжилсэн үгийн болон шүлэг найраглал зэрэг бүтээлүүд нь багтжээ.




/НХУУТ-4/

ЭШФ Т 25057-25059

Б.ІІІ: Чадраабалын Лодойдамба: Манай сургуулийнхан / Эмхт. Г.Цогзолмаа; Ариутган шүүсэн Г.Гэрэлмаа, Г.Цогзолмаа; Техник ред. П.Эрдэнэбаатар; Эх бэлт. Т.Түвшинжаргал; Хавтасны диз. Б.Эрдэнэбулган.- 2019.- 146х.-ISBN 978-99978-3-283-2.

Энэ удаа зохиолчийн Манай сургуулийнхан туужийн орчуулгыг эмхэтгэжээ.



/НХУУТ-4/

ЭШФ Т 25060-25062

Б.ІV: Далантайн Тарва: Дамирангийнхан / Эх бэлт. Т.Түвшинжаргал; Техник ред. П.Эрдэнэбаатар; Эмхт. Г.Цогзолмаа; Ариутган шүүсэн Г.Гэрэлмаа, Г.Цогзолмаа; Хавтасны диз. Б.Эрдэнэбулган.- 2020.- 135х.- ISBN 978-99978-3-358-7.

Энэ цагийн бүтээн байгуулалтын үед Монголын хөдөлмөрчид яаж зүтгэн ажиллаж байгааг энэхүү Дамирангийнхан хэмээх тууж өгүүлдэг.



/НХУУТ-4/

ЭШФ Т 25063-25065




Б.В: Дашзэвэгийн Сэнгээ.- 2020.- 208х.- ISBN 978-99962-75-27-2.

Энэхүү ботид та бүхэн зохиолчийн <<Аюуш>> тууж, <<Үнэн>> дуурийг хятад, монгол хэлээр зэрэгцүүлэн унших боломжтой.

/НХУУТ-4

ЭШФ Т 25066-25068



Чойжилсүрэн Д. Сургаалын өглөг / Хян. Ш.Чоймаа; Бичвэрийг бичсэн Дагиймаа.- УБ.: Улаанбаатар принтинг, 2021.- 48х.

Зүйр цэцэн үг, сургаал үг бол ямар нэгэн юмыг сануулсан хүмүүжүүлэх чанартай байдаг. Эртний сургаалаас зарим утга санааг аван бас өөрийн амьдрал дээр тохиолдсон санамж шүүмжийг эвлүүлэн уг бүтээлд сургаалын үгээ бичлээ.

84(1)2

Ч 754

/НХУУТ-5/

ЭШФ Б 30741-30745



Барикко А. Торго: Монсудар утга зохиол: № 35 / Ред. Ш.Баярмагнай, Д.Очирмаа; Орчуулгын ред. Г.Сугиррагчаа; Англи хэлнээс орч. М.Ганцацрал; Эх бэлт. С.Батжаргал.- УБ.: Адмон принт, 2020.- 118х.- ISBN 978-99973-1-897-8.

Торго романыг анх удаа ийнхүү монгол хэлээр орчуулан, уншигчдын хүртээл болгожээ. 1861 онд Францын Лавилье хэмээх жижиг хотод эхлэх үйл явдлын гол баатар бол 32 настай Эрве Жонкур хэмээх эр юм. Тэрээр худалдаачин агаад цор ганц төрлийн бараа арилжаалдаг нь туйлын үнэтэй атлаа тун ч эмзэг торгоны хүр хорхой ажээ. Хүр хорхойн авгалдайн шүлснээс торгоны түүхий эд гаргаж авна. Үндсэндээ энэ наймаа тун энгийн агаад ашигтай ч үүнийг эрхлэх хүн танил тал сайтай төдийгүй алс холын аян замд гарахаас айж бэрхшээдэггүй нэгэн. Европт буй бүх хүр хорхой халдварт өвчинд нэрвэгдэж дэлхий даяар эрүүл хорхой нэг ч олдохгүй болсноор зохиолын гол баатар аялалд гарч байгаагаар романы үйл явдал эхэлдэг.

84(4Ита)-44

Б 294

/НХУУТ-4, ГНОФ-6/

ЭШФ Б 30788-30790



Юкио М. Багт хүний наманчлал: Монсудар утга зохиол: № 36 / Ред. Ж.Хишигжаргал, Д.Очирмаа; Япон хэлнээс орч. Ц.Онон; Эх бэлт. Д.Очирмаа.- УБ.: Адмон принт, 2021.- 214х.- ISBN 978-99973-1-569-4.

Зохиолын тухайд төлөвшлийн романы шинжийг агуулах бөгөөд гол баатар болох ихийг эргэцүүлж боддог, өршөөлгүй, ил шулуухан зантай Кохан хэмээх би хүүрнэгч хэрхэн том хүн болж, насанд хүрч буй тухайгаа хүүрнэн өгүүлнэ. Төлөвшлийн романы онцлог шинж болох зөрчлийн тухай эл зохиолд тунчиг нарийн тусгажээ.

84(5Яп)-44

Ю 241

/НХУУТ-4, ГНОФ-3/

ЭШФ Б 30791-30793

Камю А. **Тахал** / Ред. Ж.Хишигжаргал, Д.Очирмаа; Орчуулгын ред. Б.Ундрах, Б.Дөлгөөн; Орос хэлнээс орч. В.Батболд; Эх бэлт. Э.Энэрэл; Хавтасны зур. Б.Төрмөнх.- УБ.: Адмон принт, 2020.- 332х.- ISBN 978-99973-1-906-7.



Бүтээлийн нэр “Тахал” бөгөөд өнгөц харахад нууцлаг тахалд бүслэгдсэн Алжирын эргийн нэгэн хотын тухай ил тод өгүүлэх мэт. Гэвч уг ном халдварт өвчний тухай хүүрнэсэн жирийн нэг түүх биш, харин бидний ахуй байдал, нэг нэгнийхээ өмнө хүлээсэн эрх үүргийн тухай нягт эргэцүүлэл ажээ.

84(4Фр)-44

К 18

/НХУУТ-4, ГНОФ-3/

ЭШФ Б 30776-30778

Оруэлл Ж. **Мянга есөн зуун наян дөрөв** / Ред. Ж.Хишигжаргал, Б.Оюунханд, Д.Очирмаа; Орчуулгын ред. Н.Жавхлан; Англи хэлнээс орч. Д.Чулуундорж; Эх бэлт. Д.Очирмаа; Хавтасны зур. С.Батжаргал.- УБ.: Адмон принт, 2021.- 331х.- ISBN 978-99973-1-863-3.



Энэхүү "Мянга есөн зуун наян дөрөв" роман нь XX зууны хамгийн сод бүтээлүүдийн нэг юм. Арал дээр байх хугацаандаа үй их зовж шаналан үхэлд ч тун ойртсон мөртөө "бүтээлч" онгоддоо харагдчихаад байсан Жорж Оруэллийн зохиолоо дуусгах гэсэн туйлын бэрх 'аяллын' тухай өгүүлэх Роберт МакКрамын түүхийг өгүүлнэ.


84(4Их Бр)-44

О-48

/НХУУТ-4, ГНОФ-3/

ЭШФ Б 30779-30781

Шаланский Ю. **Алдагдсан зүйлийн жагсаалт** / Ред. Ш.Баярмагнай, Д.Очирмаа; Эх бэлт. Э.Энэрэл; Герман хэлнээс орч. Б.Ундрах.- УБ.: Адмон, 2019.- 310х.- ISBN 978-99973-1-853-4.



Энэхүү бүтээлд сэдэв, үйл явдал өрнөж буй он цаг, бичлэгийн хэв маягаараа ялгаатай 12 өгүүллэгийг багтаажээ. Өгүүллэгүүдэд ганцхан нийтлэг зүйл бий. Тэр нь юу гэвэл өгүүллэгийн сэжим нь бүгд алга болсон зүйл төдийгүй мөнх бус зүйл.

84(4Гер)-44

Ш 201

/НХУУТ-4, ГНОФ-3/

ЭШФ Б 30782-30784

Оруэлл Ж. **Амьтны ферм**: Улс төрийн элэглэл= Animal farm / Ред. Б.Оюунханд, Д.Очирмаа; Орч. О.Тогоохүү; Англи хэлнээс орч. О.Тогоохүү; Орчуулгын ред. Н.Жавхлан; Эх бэлт. Д.Очирмаа; Хавтасны зур. Э.Базаррагчаа.- УБ.: Адмон принт, 2021.- 153х.- ISBN 978-99973-1-931-9.



Энэхүү зохиолд нэгэн фермийн амьтад өөрсдийг нь дарлан мөлжиж, амь залгуулах төдийхнөөр аргацаан, хүнд хүчир хөдөлмөрт нухлах эзэн ХҮН-ий эсрэг бослого гаргаж буй тухай ёгтлон өгүүлжээ.

84(4ИхБр)-445

О 47

/НХУУТ-4, ГНОФ-3/

ЭШФ Б 30785-30787

ШАШИН СУДЛАЛ



Карритэрс М. **Будда**: Тун товчхон танилцуулга / Техник ред. В.Уянга; Орч. Т.Ариунсанаа; Хавтасны диз. Н.Бямбацогт; Эх бэлт. Д.Цэрэндулам.- УБ.: Мөнхийн үсэг, 2021.- 107х.- ISBN 978-9919-500-30-6.

Тус бүтээлд Буддагийн амьдрал, номлолын талаарх ээдрээтэй бөгөөд зөрчилтэй судруудыг шинжилжээ. Буддаг амьд ахуй цагийн Энэтхэг орны нийгмийн байдал ямар байсан бэ? Өнөөдөр шашин болон хувирсан номлолыг Будда хэрхэн анх дэвшүүлсэн бэ? Олон зуун жил өнгөрөөд байхад буддын номлол яагаад усталгүй үлдэв зэрэг асуултад хариулт өгөх, Энэтхэгийн хойгт 1500 гаруй жил оршсон энэ номлол XIII зуунаас дэлхий даяар түгэж эхэлсэн бөгөөд XX зуун гэхэд Будда дэлхийн хамгийн нөлөөтэй сэтгэгчдийн нэг болох талаар дурджээ.

86.35

К 268

/НХУУТ-4, ГНОФ-4/

ЭШФ Б 30723-30724



Дармадала **Монголын номын гарлага** / Орчуулж, эх бичгийн судалгаа хийсэн Л.Тэрбиш; Техник ред. Г.Жаргал, Т.Чулуун-Эрдэнэ, Д.Оюун-Эрдэнэ, Ш.Оюундулам; Хавтасны диз. Э.Түмэнжаргал; Эх бэлт. Б.Пүрэвдэлгэр.- УБ.: Соёмбо принтинг, 2021.- 483х.- ISBN 978-9919-504-56-4.

Энэхүү зохиолд Монгол орноо Бурханы шашныг дэлгэрүүлэхэд түүхэн үүрэг гүйцэтгэсэн номт хаад, хутагт хувилгаад, мэргэн бандида, сүм хийдийн намтар түүх, номын алтан аргамжийн бодлогыг тод томруун гаргажээ.

86.35(1)

Д 369

/НХУУТ-7, ГНОФ-5/

ЭШФ Т 25177-25179



Лувсанцэмбэл гүшри. **Монголын номын гарлага** / Орчуулж, эх бичгийн судалгаа хийсэн Л.Тэрбиш; Утгын ред. Ш.Чоймаа; Техник ред. Г.Жаргал, Т.Чулуун-Эрдэнэ, Д.Оюун-Эрдэнэ, Ш.Оюундулам; Хавтасны диз. Э.Түмэнжаргал; Эх бэлт. Э.Уранбилэг.- УБ.: Соёмбо принтинг, 2021.- 335х.- ISBN 978-9919-504-57-1.

Энэхүү зохиолд Монгол орноо Бурханы шашныг дэлгэрүүлэхэд түүхэн үүрэг гүйцэтгэсэн номт хаад, хутагт хувилгаад, мэргэн бандида, сүм хийдийн намтар түүх, номын алтан аргамжийн бодлогыг тод томруун гаргажээ.

86.35(1)

Л 819

/НХУУТ-7, ГНОФ-5/

ЭШФ Т 25180-25182



Бат сүзэгт бандида хамба Жамьянгарав: Б.Ш: Зарим судрынх нь бичвэр, орчуулга хийгээд судлалын бүтээлийн эмхэтгэл / Ред. Ч.Пүрэвдорж; Эрхэлж хэвл. Д.Ганболд, Ч.Пүрэвдорж; Эх бэлт. Ү.Цэндсүрэн; Хавтасны диз. Ц.Түмэнжаргал.- УБ.: Соёмбо принтинг, 2021.- 274х.- ISBN 978-9919257095.

Тус ботид Жамьянгарав бандидагийн туурвисан судруудаас заримыг эхээр нь, заримыг орчуулж хэвлүүлж буй бөгөөд ялангуяа Монголын хаадын үе залгамжийн тухай судрыг анх удаа орчуулан тайлбарлаж

мөн холбогдох өгүүллийг бичсэн ба үүнээс гадна намтар бүтээлээр сүүлийн 10 жилд судалгаа хийсэн эрдэмтдийн өгүүлэл, тэмдэглэлийг Гэгээнтэний эснэсний 160 жилийн ойд зориулан хэвлүүлжээ.

86.36+83.3

Б 33

/НХУУТ-5/

ЭШФ Т 25159-25161

Ричэс Ж. **Библи**: Тун товчхон танилцуулга / Орч. Т.Ариунсанаа; Техник ред. Б.Болдбаатар, В.Уянга; Хавтасны диз. Н.Бямбацогт; Эх бэлт. Д.Цэрэндулам. - 2 дахь хэвл.- УБ.: Мөнхийн үсэг, 2021.- 159х.- ISBN 978-9919-500-29-0.



Энэхүү номонд Библийн тухай өөр өөр ард түмний тэмдэглэн үлдээсэн судруудын шинжилгээ судалгааны талаар тусгасны дээр Библи яагаад олон янзаар ойлгогддог, Библи ямар шүүмжлэл дагуулж байсан гэх зэрэг асуудлуудыг ч хөндсөн байна. Улмаар Библи өрнөдийн соёлд хэрхэн асар их нөлөө үзүүлснийг болон үүнийг поп урлагт болон улс төрд хэрхэн ашиглаж буй талаар тайлбарлажээ.

86.37


Р 569

/НХУУТ-4, ГНОФ 4/

ЭШФ Б 30721-30722

ГҮН УХААН

Нэйжэл Ж. **Мэдлэг: Тун товчхон танилцуулга= Knowledge: A very short introduction** / Орч. Т.Ариунсанаа; Техник ред. Б.Болдбаатар, В.Уянга; Хавтасны диз. Н.Бямбацогт; Эх бэлт. Д.Цэрэндулам.- УБ.: Нэпко, 2021.- 130х.- ISBN 978-9919-500-88-7.



Мэдлэг гэж юу вэ? Энэ зүйл итгэл үнэмшлээс юугаараа өөр вэ? Бидний эргэн тойрны ертөнц зүүд биш үнэхээр бодитой гэдгийн яаж мэдэх вэ? Мэдлэг судлал буюу эпистемологи гэдэг бол энэ мэт асуултуудад хариулт хайдаг философийн салбар ухаан юм. Энэхүү мэдлэг: Тун товчхон танилцуулга ном сонгодог болон орчин үеийн эпистемологийг шинжлэхдээ эртний релятивизмаас өнөөгийн интернетийн мэдээнд эргэлзсэн эргэлзээг авч үзнэ. Хэл шинжлэл, сэтгэл судлал, философи, баримт, үзэл санаанууд дээр тулгуурлан зохиогч Жэннифер Нэйжэл мэдлэгийн талаар бид одоогоор юу мэдэж байгааг тайлбарлажээ.


87.22

Н 92

/НХУУТ-4, ГНОФ-4/

ЭШФ Б 30699-30700

Бён Ч. Х. **Тамирдсан нийгэм** / Орчуулгын ред. Б.Баясгалан; Орч. А.Амармэнд; Хавтасны диз. З.Мандах.- УБ.: Мөнхийн үсэг, 2020.- 96х.- ISBN 978-9919-9637-0-5.




Солонгос-Германы философич Хан Бён Чолийн “Тамирдсан нийгэм” хэмээх философийн бүтээл. Орчин үеийн буюу одоогийн капиталист нийгмийн эмгэгүүдийн талаар хийсэн шинжилгээ гэж ерөнхийд нь томьёолж болох байх. Өнөөдөр сэтгэл гутрал зэрэг сэтгэцийн эмгэгүүд өмнөх үеэс илүү түгээмэл болсон санагддаг. Чухам энэ бүхний цаана юу байгаа вэ? Орчин үеийн нийгмийн хүн төрөлхтөнд үзүүлж буй нөлөө хийгээд эдгээр нь өмнөх үеийн нийгмээс юугаараа ялгаатай вэ? гэх зэрэг асуудлуудыг хөнджээ.

87.3

Б 398

/НХУУТ-4, ГНОФ-3/

ЭШФ Б 30794-30796



Инвүүд Б. Стоицизм: Тун товчхон танилцуулга / Ред. Б.Баяраа; Техник ред. Б.Болдбаатар, В.Уянга; Орч. Т.Ариунсанаа; Хавтасны диз. Н.Бямбацогт; Эх бэлт. Д.Цэрэндулам.- УБ.: Мөнхийн үсэг, 2021.- 109х.- ISBN 978-9919-500-90-0.

Энэхүү бүтээлд Стоик философийг чамд танилцуулахын хамт эртний энэ сэтгэлгээ хэрхэн хөгжсөөр өнөөгийн стоик хөдөлгөөн болж хувирсныг тайлбарласны дээр МЭӨ IV зууны Герегт үүссэн эл философийн сургуулийн түүхийг уудлан, уг урсгалынхантай Платон, Аристотэл, тэдний залгамжлагчид болон Эпикурчууд ямар харилцаатай байсан, улмаар уг сэтгэлгээ барууны ертөнцөд яаж нөлөөлснийг болон өнөөгийн стоик хөдөлгөөн эртний стоик үзлээс өөр хэдий ч нийтлэг зүйлс бас бий ба уг сэтгэлгээ Сэнэка, Эпиктэт, Марк Аврелий нарыг нэгтгээд зогсохгүй Зенон, Клеант, Хриссип нараас ч эхтэй тухай өгүүлжээ.

87.3

И 589

/НХУУТ-4, ГНОФ-4/

ЭШФ Б 30727-30728



Прист Г. Логик: Тун товчхон танилцуулга / Орч.Т.Ариунсанаа; Техник ред. Б.Болдбаатар, В.Уянга; Хавтасны диз. Н.Бямбацогт; Эх бэлт. Д.Цэрэндулам.- УБ.: Мөнхийн үсэг, 2021.- 160х.- ISBN 978-99978-51-88-8.

Тус бүтээлд орчин үеийн логик гэж юу вэ?, логикийн талаар мэдэх яагаад ашигтай вэ?, Бурхан байдаг уу? гэх асуултаас авхуулаад магадлалын онолын дотоод зөрчлүүд, шийдвэр гаргалтын онолуудын тухай энгийн үг хэллэгээр тайлбарлажээ. Мөн алгоритм, аксиом, математикийн баталгаа гэсэн сэдвүүдийг ч хөнджээ.

87.4

П 771

/НХУУТ-4, ГНОФ-4/

ЭШФ Б 30725-30726



Питерсон Ж. Б. Амьдралын 12 дүрэм: Хаосын эсрэг ерөндөг / Ред. Ж.Хишигжаргал, Д.Очирмаа; Орчуулгын ред. Э.Зориг, Н.Жавхлан; Англи хэлнээс орч. Э.Цэнгэлсайхан; Эх бэлт. Э.Энэрэл; Хавтасны диз. Д.Пүрэвсүрэн.- УБ.: Адмон принт, 2020.- 438х.- ISBN 978-99973-1-905-0.

Зохиогч энэхүү номдоо, утга учиртай амьдрахад зориулсан баялаг бөгөөд хэрэгжүүлж болохуйц, бусдыг шүүмжлэхээсээ өмнө орон гэрээ төгс эмхэлж цэгцлэхээс эхлэн өөрийгөө өнөөдрийн хэн нэгэнтэй бус, харин өчигдөр хэн байсантайгаа харьцуулах ёстойг багтаасан арван хоёр дүрмийг тусгажээ.

87.7

П 352

/НХУУТ-5, ГНОФ-5/

ЭШФ Т 25036-25038



Золзаяа М. Ёс зүй, философи, шинжлэх ухааны талаар: Өгүүлэл, илтгэл, нийтлэлийн эмхэтгэл / Зураач Н.Сүндэрьяа; Эх бэлт. Б.Сарнай; Хавтасны диз. У.Билэгт-Од.- УБ.: Соёмбо принтинг, 2021.- 352х.- ISBN 978-9919-25-269-4.

Энэхүү бүтээлд ёс зүйн сэтгэлгээний түүх, эх сурвалжийн шинжилгээ, хэрэглээний ёс зүйн тулгамдсан асуудал, өнөөгийн нийгмийн ёс суртахууны төлөв байдал, философийн судалгаа, нэр томьёо, шинжлэх

ухааны талаар бичсэн эрдэм шинжилгээний өгүүлэл, илтгэл, нийтлэлийг эмхэтгэжээ. Мөн академич Г.Чулуунбаатар, ахмад судлаач А.Жамбал, профессор Ц.Пүрэв нартай хамтран толилуулсан илтгэлүүдээ багтаажээ.

87.7я43

З 649

/НХУУТ-4, ГНОФ-5/

ЭШФ Б 30800-30802

Кондо М., Сонэншейн С. **Баяр баясал авчрах ажлын эмх цэгц** / Ред. Б.Батцэцэг, Д.Очирмаа; Орч. Л.Саруултөгс; Эх бэлт. Э.Энэрэл.- УБ.: Адмон принт, 2021.- 269х.- ISBN 978-99973-1-926-5.


Уг номд ажлын орчноо цэгцлэхээс гадна дижитал файл болон цагийн хуваарь, шийдвэр гаргалт, хүмүүсийн хүрээлэл гэх мэт биет болон биет бус зүйлсийг цэгцлэх замаар хэрхэн ажлаасаа аз жаргал, урам зориг авч болох тухай өгүүлэх юм. Гэр орноо эмхэлж янзалснаар амьдрал илүү гэрэлтдэг бол ажлын байраа цэгцэлснээр карьер өсөж, ажил цэгцэрч бүтэмжтэй болдог. Энэ л нууцыг энэхүү номоор дамжуулан хүргэхийг зорьжээ.

87.815

К 642

/НХУУТ-5, ГНОФ-5/

ЭШФ Б 30687-30689



СЭТГЭЛ СУДЛАЛ

Баярмаа Э. **Сэтгэц заслын сонгодог аргуудын хялбаршуулсан практик ойлголт** / Хян. Д.Хишигдэлгэр; Зургийг эвлүүлсэн Э.Баярмаа; Диз. Э.Мөнхтөр.- УБ.: Соёмбо принтинг.

88.3

Б 381

Цувр.1: Психодинамик сэтгэц засал / Ред. Г.Сарантуяа, Ч.Базар; Зургийг эвлүүлсэн Э.Баярмаа; Диз. Э.Мөнхтөр.- 2020.- 192х.- ISBN 978-9919-20-681-9.

Шүүмжлээд, загнаад, уурлаад, хэлээд, заагаад, зааварлаад сургаал айлдаад хүнийг хялбархан өөрчилчихдөггүй. Зан үйлийг засаж, чиглүүлэх нь мэргэжлийн арга зүй шаардах үйл явц юм. Тэрхүү арга зүйг эзэмшихэд уг бүтээл тусална. Энэхүү ном нь онолоо өөр өнцгөөс харахад туслах бөгөөд сэтгэл судлалын суурь ойлголтгүй хүн ч уншиж болохоор хялбаршуулсан, амьдралд ойр, практик ойлголт өгөх бүтээл юм.



/НХУУТ-7, ГНОФ-5/

ЭШФ Т 25150-25152

Цувр.2: Аналитик сэтгэц засал / Ред. Г.Сарантуяа, Ч.Базар; Зургийг эвлүүлсэн Э.Баярмаа; Диз. Э.Мөнхтөр; Эх бэлт. П.Номинцэцэг.- 2021.- 275х.- ISBN 978-9919-25-430-8.

Нарийн, төвөгтэй, хийсвэр, онолын ойлголтуудыг энгийн, хялбар, ойлгомжтой байдлаар хүргэж байгаа нь энэхүү цуврал бүтээлийн онцлог юм. Онолыг хялбаршуулсан байдлаар тайлбарлаад зогсох бус, тухайн онолыг ажил амьдралдаа хэрэглэх арга, техникийг заана.



/НХУУТ-7, ГНОФ-5/

ЭШФ Т 25153-25155

НОМ ЗҮЙН ЛАВЛАГААНЫ ГАРЫН АВЛАГА



Монгол улсын Үндэсний номын сан дахь монгол бичгээрх сурвалж бичиг: Бүртгэн мэдээлэх номзүй: Б.І / Ерөн. ред. Э.Пүрэвжав; Хариуцлагатай ред. Д.Энхтунгалаг; Хян. Г.Ням-Очир; Эмхт. Д.Энхтунгалаг, Т.Баярлах, Б.Цогжаргал ба бус.; Зөвл. Б.Ичинхорлоо, Д.Заяабаатар; Эх бэлт. Т.Энхтунгалаг; Хавтасны диз. Э.Доржханд.- УБ.: Соёмбо принтинг, 2020.- 668х.- ISBN 978-9919-9567-8-3.



Энэхүү бүтээлд эх сурвалж тус бүрийн зохиогч, номын нэр, ном судрыг бүтээхэд оролцсон хүн, хэвлэгдсэн он, хэвлэсэн газар, хуудас, хэмжээ, хэвлэлийн төрөл, онцлог байдал, материалын төрөл, ангийн заалт, сан хөмрөг дэх бүртгэлийн дугаар, тайлбар гэх мэт хэвлэн нийтлэлийн мэдээг аль болох дэлгэрэнгүй оруулж, зохиогч, номын нэр, оролцогчдын тухай мэдээг монгол хэл, эх бичиг судлалд баримталж буй эрдэм шинжилгээний галигаар галигласан болно. Мөн хэвлэн нийтлэлийн мэдээг оруулахдаа бичигдсэн, хэвлэгдсэн оны билгийн тооллыг аргын тооллоор давхар тодотгон өгч, тайлбар хэсэгт уг сурвалж бичгийн бүрэн бүтэн эсэх, ямархуу гэмтэлтэй тэргүүтнийг тодорхойлж өгөв. Бүртгэлийн төгсгөлд номыг бүтээхэд оролцсон

хүмүүсийн нэрийн хэлхээсийг кирилл үсэг болон эрдэм шинжилгээний галиг үсгээр тус тусад нь хийж хавсарган оруулжээ.

91

М 692

Б.І / Хавтасны диз. Э.Доржханд.- 668х.- ISBN 978-9919-9567-8-3.

/ЛавФ-1/

ЭШФ Т 25012-25013

Б.ІІ / Мэдээллийг бэлт. П.Гийхнаран, Б.Отгонтуяа, Ү.Доржоо ба бус.; Хавтасны диз. Т.Даваажав.- 432х.- ISBN 978-9919-9567-8-3.

/ЛавФ-1/

ЭШФ Т 25014-25015



МУИС-ийн номын сангийн ном зүйн бүртгэл-III: Олон улсын харилцаа, нийтийн удирдлагын сургуулийн багш нарын бүтээл / Ерөн. ред. Г.Цэрэн, О.Нарантуяа; Ред. С.Баттулга, Ж.Баттогтох, Г.Баасанжав; Эмхт. М.Золбоо, Б.Золзаяа, Ч.Мөнхзул ба бус.- УБ.: Удам соёл, 2021.- 470х.- ISBN 978-9919-504-72-4.

